МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

германы хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ**

15160 Улаанбаатар хот , Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Самбуугийн гудамж-22, Зоос гоёл-317
Утас: +976-70140166, 70140188,
Э-шуудан: piubaccp@gmail.com,
http://www.baccp.mn

2023.01.11 № 01/23

танай _______________ -ны № _______________-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ГАЗРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭСТ

Үйл ажиллагааны тайланг хүргүүлэх тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн I болон II,III шатны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг 2022 оны жилийн эцсийн байдлаар тус тус гарган, хүргүүлж байна.

Хавсралт ..31... хуудастай.

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ [signature] Г.ЭРДЭНЭБАЯСГАЛАН

УЛААНБААТАР ХОТ
БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ ... УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ ТБАГ
9020070899 6599737

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын
хавсралт Бодлогын баримт бичгийн хэрэгжилт,
захиргааны байгууллагын үйл ажиллагаанд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
нийтлэг журмын хүснэгт 5

# БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ I ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

<table>
<tr><th>№</th><th colspan="2">Төслийн агуулга</th><th colspan="4">Гүйцэтгэл</th></tr>
<tr><td>1</td><td colspan="2">Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар</td><td colspan="4">“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” I төсөл<br>Шийдвэр: 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улс-ХБНГУ Засгийн газар хоорондын байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр болон Төслийн хэрэгжилтийг сунгах тухай 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн шийдвэр<br>Төслийн дугаар: BMZ 2012 65 511-I шат<br>Төслийн зорилго: Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг (орчны бүс болон экологийн коридорыг) бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино.</td></tr>
<tr><td>2</td><td colspan="2">Санхүүжилт-ийн эх үүсвэр</td><td colspan="4">ХБНГУ-ын Засгийн газар - Буцалтгүй тусламж<br>Монгол Улсын Засгийн газар</td></tr>
<tr><td rowspan="3">3</td><td colspan="2" rowspan="3">Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа</td><td colspan="4">Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОАЖЯ, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх баг</td></tr>
<tr><td colspan="4">Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, БОАЖЯ-ны ТХБНУГ, ТХГН-ийн хамгаалалтын захиргаад</td></tr>
<tr><td colspan="4">Хэрэгжих хугацаа: 7 жил 7 сар: 2015.05.01 - 2022.12.31 /I шат/</td></tr>
<tr><td>4</td><td colspan="2">Төсөл, хөтөлбөрийн зорилтууд</td><td colspan="4">Зорилт 1: Тусгай хамгаалалттай газар нутгууд /ТХГН/ болон тэдгээрийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайжруулах, төслийн бэлтгэл хангах,<br>Зорилт 2: ТХГН-ийн батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх,<br>Зорилт 3: Үндэсний болон бүсийн түвшинд ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх,<br>Зорилт 4: Сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа.</td></tr>
<tr><td rowspan="3">5</td><td rowspan="3">Зардал</td><td>Төсөв (Нийт зардал)</td><td colspan="4">Төслийн I үе шатны нийт төсөв 15.3 сая евро.<br>ХБНГУ-ын Засгийн газар 11.5 сая евро,<br>Монгол Улсын Засгийн Газар 6.65 тэрбум төгрөг.</td></tr>
<tr><td>Үүнд:</td><td>Төсөв (2022 он)</td><td colspan="2">Гүйцэтгэл</td><td>Хувь</td></tr>
<tr><td>ХБНГУ-ын Засгийн газар</td><td>7,213,150,000 төгрөг</td><td>2,167,880.15 евро</td><td>7,213,150,000 төгрөг</td><td>100 %</td></tr>
<tr><td>6</td><td colspan="2">Төсөл, хөтөлбөрийн зорилт:</td><td colspan="4">2022 оны Үйл ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөний дагуу /2022.06.02-ны өдрийн байдлаар/ биелэлтийг гаргав.</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | **1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:** Тусгай хамгаалалттай газар нутгууд болон тэдгээрийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг сайжруулах, төслийн бэлтгэл хангах | **1. Баригдсан барилга байгууламжуудад байгаль орчны үнэлгээ хийх ажлын хүрээнд /ҮАТ 1.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/154 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Үнэт байгаль” ХХК-тай ГШБ-1/0821, 21/191 дугаартай *70,000,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий гэрээг 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулж ажилласны дүнд зөвлөх үйлчилгээний ажлын эцсийн тайланг тус яамны БОҮАХ-ээр 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хэлэлцэж, ажлыг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэр гарсны дагуу тайлан хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг он дамжин албажуулснаар, 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр үлдэгдэл санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Энэхүү ажлыг гүйцэтгэснээр төслийн хүрээнд баригдсан нийт 55 барилгын байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг үнэлж, барилга тус бүр дээр дүгнэлт гаргасан. |
| | **2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:** Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | *Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем*<br>*6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.*<br><br>**1. Дэд төслийн хүрээнд баригдсан ХЗ, СМТ, байгаль хамгаалагчийн байруудыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/51 дугаартай “Хөрөнгө зарцуулах тухай” тушаалаар MON/ICB019/2019 дугаартай € 286,624.00 үнийн дүн бүхий ажлын гэрээг “Ай Ти Зон” ХХК-тай тус оны 05 дугаар сарын 13-ны өдөр байгуулсны дагуу гүйцэтгэгчийн нийлүүлэх нийт 575 ширхэг тоног төхөөрөмжийг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авсан. Тоног төхөөрөмжийн түгээлтийг гэрээний дагуу нийт 12 ХЗ-нд 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хийж дуусгасан тул гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр үлдэгдэл санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%**<br>Энэхүү ажлын дүнд дэд төсөлд хамрагдсан нийт 11 ХЗ, СМТ, байгаль хамгаалагчийн байруудад компьютер, тоног төхөөрөмж бүрэн хангасан. Мөн УТХГ-ын ХЗ-ны менежментийг сайжруулах зорилгоор 2018-2020 онуудад төслийн хүрээнд баригдсан Хангайн бүсийн төв, 1ХЗ, 5 СМТ болон байгаль хамгаалагчийн 47 байрыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах дэд төсөлд хамрагдсан нийт 12 ХЗ, СМТ, байгаль хамгаалагчийн байруудыг компьютер, тоног төхөөрөмжөөр тус тус бүрэн хангасан.<br><br>**2. Зэд Хантай Бүтээлийн нурууны ДЦГ, Онон Балжийн БЦГ, Хорго тэрхийн цагаан нуурын БЦГ-ын орчны бүсийн ард иргэдийн амьжиргааг дэмжих үйл ажиллагааны ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/386 дугаарт тушаалын дагуу тендерийн ялагч “Дугант бар” ХХК-тай ҮТА-№10-2020 дугаартай 520,496,840.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгуулж ажилласны дүнд Хорго-Тэрхийн Цагаан нуурын БЦГ-ын жуулчдад үйлчлэх худалдааны цэгийг байгуулж, байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдөр ажиллуулан, хүлээн авахаар шийдвэрлэсэн. Гэрээний дагуу Онон Балжийн БЦГ-т трактор 1ш, чиргүүл 1ш, хадуур 1ш, тармуур 1ш, хаман боогч 1 ш зэрэг хадлангийн тоног төхөөрөмжийг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр нийлүүлсэн. Зэд Хантай Бүтээлийн нурууны ДЦГ-ын ХЗ-нд |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:** Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | төмс, хүнсний ногооны 40 тонны зоорь, дагалдах хэрэгслийн хамт, 120 м2-ийн нийлэг хальсан хүлэмж-3 ширхэг (тус бүр дуслын усалгааны системтэй)-ийг хүлээн авах улсын комиссыг 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ажиллуулж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгч байгууллага нь биелэлтийг Газрын харилцаа, зургийн зохиогчоор баталгаажуулж, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ирүүлснээр гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил- Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес 3.3.7. Хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, мал нядлах, мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, загасны аж ахуй, зөгийн аж ахуй, төмс, хүнсний ногоо тарих, хадгалах, боловсруулах, хүлэмжийн аж ахуй, жимс, жимсгэнэ боловсруулах, үр тарианы аж ахуй, талх, нарийн боовны цех, цэвэр ус үйлдвэрлэх, ургамлын цай үйлдвэрлэх болон бусад);*<br><br>**3. /Отгонтэнгэр УТХГ Дорнод УТХГ болон Хангайн нурууны БЦГ хамгаалалтын захиргааны/ Орчны бүсийн ард иргэдийн амьжиргааг дэмжих тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/171 дугаартай тушаалаар тендерийн ялагч "МБ Инжиниринг" ХХК-тай 01-05/21, 21/199 дугаартай *643,228.700.00 төгрөгийн* үнийн дүн бүхий гэрээг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсны дагуу 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдөр газар дээр нь танилцан шалгаж, трактор 3ш, анжис 2ш, үрлэгч 2ш, хадуур 3ш, тармуур 3ш, хаман боогч 3ш, чиргүүл 3ш, тэжээл бутлагч 2ш, үр будаа ариутгагч 1ш зэрэг нийт 22 ширхэг техник, тоног төхөөрөмжийг биет байдлын болон эрхийн доголдолгүй, гэрээнд заасан тоо ёсоор бүрэн хүлээлцсэн болно. Тоног төхөөрөмжийн түгээлтийг гэрээний дагуу Дорнод, Отгонтэнгэрийн УТХГ, Хангайн нурууны БЦГ-ын нийт 3 ХЗ-нд 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн дотор хийж дуусгасан тул гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр үлдэгдэл санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%**<br>Энэхүү ажлын дүнд дэд төсөлд хамрагдсан ХЗ байгалийн хадлан бэлтгэх, хүнсний ногоо, тариалангийн аж ахуй эрхлэх, илүүдлийг зах зээлд борлуулж, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжоор хангасан.<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин*<br>*2.5.8. Агаар болон орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр болон хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.*<br><br>**4. Орчны бүсийн сангийн үйл ажиллагааг дэмжиж техникийн зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/142 дугаартай тушаалаар "Бодлого судлалын төв" ТББ-тай CS-01/0921 дугаартай € *50,000.00* үнийн дүн бүхий ажлын гэрээг 2021 оны 08 дугаар 15-ны өдөр байгуулж ажилласны дүнд Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн танилцуулгыг 5 сумын нийт 900 гаруй хүнд хийж, үүнээс 166 малчин нийт 1.4 тэрбум гаруй төгрөгийн зээлийг авсан байна. Гүйцэтгэлийн эцсийн тайланг 2022 оны 01 дүгээр сарын 19- |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:** Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | ний өдөр төслийн дэргэдэх “Биологийн олон янз байдлыг хамгаалах мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж, ажлыг хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу тайлан хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>ТХГН-ийн Орчны бүсийн малчид, иргэдийн амьжиргааг дэмжих, бэлчээрийн доройтлыг бууруулах, нөхөн сэргээх, малын чанарыг сайжруулж, тоо толгойг 10%-аар бууруулах юм.<br><br>**5. Дэд төслийн хүрээнд хамгаалалтын захиргаадыг /хогны машин, бохир соруулдаг машин/ бусад тээврийн хэрэгслээр хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11 сарын 12-ны А/251 дугаартай тушаалаар “Еврохан” ХХК-тай MON/ICB01/2020 болон 21/271 дугаартай € 198,000.00 үнийн дүн бүхий ажлын гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсны дагуу 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдөр газар дээр нь танилцан шалгаж, хогны 4 ширхэг машин контейнерын хамт, нэмэлт 5 ширхэг контейнер, бохир соруулах 2 машиныг биет байдлын болон эрхийн доголдолгүй, гэрээнд заасан тоо ёсоор бүрэн хүлээлцсэн болно. Тоног төхөөрөмжийг гэрээний дагуу Горхи Тэрэлжийн БЦГ, Отгонтэнгэрийн УТХГ, Орхоны Хөндийн БЦГ, Хангайн нурууны БЦГ-уудын ХЗ-дад 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн дотор нийлүүлж дуусгасан тул гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр үлдэгдэл санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%**<br>УТХГ-ын Төв, Хангайн бүсийн аялал жуулчлалын гол маршрут болсон Горхи Тэрэлжийн БЦГ, Отгонтэнгэрийн УТХГ, Орхоны Хөндийн БЦГ, Хангайн нурууны БЦГ зэрэг газруудын хог хаягдал болон ариун цэврийн 00-ын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.<br><br>**6. Дэд төслийн хүрээнд хамгаалалтын захиргаадыг /бага оврын автобус/, бусад тээврийн хэрэгслээр хангах ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/191 дугаартай тушаалаар №01-03/21 дугаартай 336,000,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий бараа нийлүүлэх ажлын гэрээг “УАЗ Мега” ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулсны дагуу Дорнод, Отгонтэнгэрийн УТХГ, Хустай, Хангайн нуруу, Зэд Хантай бүтээлийн нуруу, Тарвагатай нуруу, Онон Балжийн БЦГ-ын ХЗ-дад Уаз фургон машинуудыг олгохоор 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч, нийт 7 ХЗ-нд түгээлтийг хийж дуусгасан. Актыг 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хүлээн авч гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Энэхүү ажлын дүнд дэд төсөлд хамрагдсан УТХГ-ын ХЗ-аадад судалгаа шинжилгээ хийх, хяналт мониторингийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлээд байна.<br><br>**7. Дэд төслийн хүрээнд баригдсан ХЗ болон СМТ-ийн байрны АЦБ-ийн ажилд зөвлөхийн дэмжлэгтэйгээр хяналт тавих ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/500 дугаартай тушаалаар “ЭнЭйПи Групп” ХХК-тай Хан Хэнтий, Улаантайга, Отгонтэнгэрийн УТХГ, Онон Балж, Тарвагатай нурууны БЦГ-уудын хамгаалалтын захиргааны байр, Сургалт мэдээллийн төвийн 6 барилгын АЦБ-ийн зураг төсөв боловсруулах, гүйцэтгэлд |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:** Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ҮТ08-2019 дугаартай *123,670,700.00 төгрөгийн* үнийн дүн бүхий гэрээг 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдөр байгуулсны дагуу нийт 6 барилгын АЦБ-ийн ажлын зургийг хүлээлгэн өгч, 5 барилгын ариун цэврийн байгууламжийг Улсын комисс ажиллуулан хүлээлгэн өгсөн. Үлдсэн 1 АЦБ болох Тарвагатай нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны байрны АЦБ-ийн барилгын ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр улсын комисс ажиллуулан хүлээн авсантай холбогдуулан тус зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг хүлээн авч, гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**8. Дэд төслийн хүрээнд баригдсан 2 сургалт мэдээллийн төвийн байранд ариун цэврийн байгууламж барих ажлын хүрээнд /ҮАТ 2.01/::**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/401 дугаартай тушаалаар тендерийн ялагч “Нью Урбанизм” ХХК-тай “Хан Хэнтий болон Отгонтэнгэрийн УТХГ-ын ХЗ-ны сургалт мэдээллийн төвийн байрны АЦБ барих” ҮТА№07-02/2020 дугаартай 99,279,518.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулж ажилласны дүнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгонд баригдсан Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргааны сургалт мэдээллийн төвийн ариун цэврийн байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр, Завхан аймгийн Отгон сумд баригдсан Отгонтэнгэрийн УТХГ-ын хамгаалалтын захиргааны сургалт мэдээллийн төвийн ариун цэврийн байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссыг 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр тус тус ажиллуулж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгч байгууллага нь биелэлтийг Газрын харилцаа, зургийн зохиогчоор баталгаажуулж, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ирүүлснээр гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Энэхүү ажлын дүнд УТХГ-ын Хан Хэнтий, Отгонтэнгэрийн УТХГ-ын ХЗ-ны мэргэжилтэн, ажилтан нар СМТ дотроо ариун цэврийн байгууламжтай болж, ажиллах нөхцөл сайжирсан.<br><br>9. **“Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах” ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/409 дугаартай тушаалаар 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр € 140,000.00 үнийн дүн бүхий гэрээг байгуулж ажилласны дүнд Отгонтэнгэрийийн УТХГ, Зэд хантай бүтээлийн нурууны БЦГ, Тарвагатайн нурууны БЦГ, Хангайн нурууны БЦГ, Орхоны хөндий БЦГ, Онон Балжийн БЦГ, Улаан тайгын УТХГ, Горхи Тэрэлжийн БЦГ, Хустайн БЦГ, Дорнод Монголын УТХГ, Хан-Хэнтийн УТХГ нийт 11 УТХГ-ын хамгаалалтын захиргааны орчны бүсийн 48 суманд эко кабинет бий болгож, сургууль тус бүрд 4 төрлийн 4 компьютер техник хэрэгслийг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр БОАЖЯ-нд хүлээлгэн өгснийг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Ерөнхий боловсролын нийт 48 сургуулиудад түгээж дууссан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**10. “Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг тавилга, тоног төхөөрөмжөөр** |

| | | |
|---|---|---|
| | 2-р зорилтын хүрээнд: **Хүрэх үр дүн:** Тусгай хамгаалалттай газруудын батлагдсан менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | **хангах" ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>Тус ажлыг "Дэд төслийн хүрээнд ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинетыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах" /ҮАТ 2.16/-ын ажилтай нэгтгэн багцалж, тендерийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/408 дугаартай тушаалаар "Хасу Энержи Интэрнэшнл" ХХК-тай 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр € 169,920.00 үнийн дүн бүхий гэрээг байгуулж ажилласны дүнд Отгонтэнгэрийн УТХГ, Зэд хантай бүтээлийн нурууны БЦГ, Тарвагатайн нурууны БЦГ, Хангайн нурууны БЦГ, Орхоны хөндий БЦГ, Онон Балжийн БЦГ, Улаан тайгын УТХГ, Горхи Тэрэлжийн БЦГ, Хустайн БЦГ, Дорнод Монголын УТХГ, Хан-Хэнтийн УТХГ нийт 11 УТХГ-ын орчны бүсийн 48 сумын эко кабинет тус бүрд 9 төрлийн 72 ширхэг тавилга тоног төхөөрөмжийг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр БОАЖЯ-нд хүлээлгэн өгснийг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Ерөнхий боловсролын нийт 48 сургуулиудад түгээж дууссан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**11. Орчны бүсийн ард иргэдийн амьжиргааг дэмжих ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/208 дугаар тушаалаар 311,932,826.00 төгрөгийн үнийн дүн бүхий ҮТА-№01-02/2021, 21/228 дугаартай гэрээг "Дугант бар" ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсны дагуу гүйцэтгэгч байгууллага өвлийн хүлэмжийн зураг төслийг БОАЖЯ болон Тарвагатайн нурууны БЦГ-ын ХЗ-аар 2022 оны 05 дугаар сард батлуулсан. 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр дуусах гэрээний дагуу тус ажлын гүйцэтгэлийг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр улсын комисс ажиллуулан үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан эцсийн тайланг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авч, гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**12. Дэд төслийн хүрээнд баригдсан Тарвагатайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны байрны барилгын өргөтгөлийн АЦБ барих ажлын хүрээнд /ҮАТ 2.02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/55 дугаартай тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/172 дугаар тушаалаар *238,195,207.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ҮТА-№01-01/21, 22/123 дугаартай гэрээг "Бизнес фокус" ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулаад байна. 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр дуусах гэрээний дагуу тус ажлын гүйцэтгэлийг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр улсын комисс ажиллуулан үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан эцсийн тайланг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авч гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**13. Горхи Тэрэлжийн БЦГ-т нэвчилттэй ариун цэврийн байгууламж нэмж барих ажлын хүрээнд /ҮАТ 2.03/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/197 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус |

| | | |
|---|---|---|
| | | тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/232 дугаартай тушаалаар 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр *15,961,239.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-01/22, 22/144 дугаартай ажлын гэрээг "Хидро Инженеринг" ХХК-тай байгуулсны дагуу захиалагч, ашиглагч талуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийн тайлан, захиалагчийн хяналт /Төв аймгийн ГХБХБГ/-ын тайланд үндэслэн, ариун цэврийн байгууламж барих ажлыг хүлээн авч, гэрээ дүгнэсэн актыг албажуулсан. Гүйцэтгэлийн баталгааг суллаж, чанарын баталгааг гаргуулан, 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр үлдэгдэл төлбөрийг шилжүүлсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.** |
| | **3-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:** Үндэсний болон бүсийн түвшинд ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх | **1. Бэлчээрийн менежментийн загвар төслийг шалгуур үзүүлэлттэй уялдуулан нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 3.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/58 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/121 дугаартай тушаалаар 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр *68,100,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-1/1821 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг "Шинжлэх ухааны академи, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн"-тэй байгуулсан. Загвар төслийн эцсийн тайланг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авсан бөгөөд тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцэж, тус ажлыг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу эцсийн тайланг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хүлээн авсан тул гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Бэлчээрийн тогтвортой менежментийг Хангайн нурууны БЦГ-т нэвтрүүлснээр бэлчээрийн даац, газрын доройтол буурах, хамгаалалт, нөөц, зохистой ашиглалт сайжрах, нутгийн иргэдийн амьжиргаа сайжирч, байгаль хамгаалалд оролцоо нэмэгдэж байна.<br><br>**2. ТХГН-ийн ХЗ-дын зарим үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд /ҮАТ 3.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/198 дугаартай тушаалаар 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр *34,900,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-1/2021, 21/216 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг "И-софт" ХХК-тай байгуулсны дагуу төслийн зүгээс гэрээний хугацаанд гүйцэтгэгчийн ажлын тайланг хүргүүлэх талаар удаа дараа мэдэгдсэн хэдий ч эцсийн тайланг ирүүлээгүй. Гэрээт ажлын хугацаа 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр дуусгавар болсон хэдий ч, 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр гэрээ сунгах хүсэлтийг БОАЖЯ-нд хүргүүлсэн. Тус хүсэлтээр цар тахал (Ковид-19)-ын улмаас үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тухай тайлбар өгсний дагуу нөхцөл байдлыг үндэслэн гэрээг цуцлах шийдвэрийг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 03/3181 дугаартай захиалагч талаас албан ёсоор мэдэгдсэн. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил- Шинжлэх ухаан, инноваци*<br>*2.4.17. Аж ахуйн нэгж, олон нийтэд инноваци, энтерпренёршипийн боловсрол олгох, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, технологи, танин* |

| | | |
|---|---|---|
| | | *мэдэхүйн төрөл бүрийн контент бүтээх ажлыг дэмжинэ.*<br><br>**3. ТХГН-ийн үйл ажиллагаа зорилго, байгаль хамгаалагчдын талаар иргэд нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, зөв зохистой аялалд уриалах маркетингийн аяны контент бэлтгэх жишиг төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 3.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/48 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/199 дугаартай тушаалаар 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр *34,500,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-1/1921, 21/218 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг "Рэтэ" ХХК-тай байгуулсан. Зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг тус яамны ТХБНУГ-аар 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хэлэлцүүлж, хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу гэрээний хэрэгжилтийг дүгнэж, сүүлийн санхүүжилтийг 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр гаргасан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>4. **Орон нутгийн ТХГ-ын менежментийг бэхжүүлэх, БОЯБ холбоос нутгийн хамгааллыг хөгжүүлэх (ҮТ-06/2019) загвар төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 3.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/628 дугаартай тушаалаар тендерийн ялагч "Коконэт" ТББ-тай байгуулагдсан *234,711,250.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ҮТ-06/2019 дугаартай гэрээний дагуу загвар төслийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хэлэлцэж, тус ажлыг хүлээн авахаар шийдвэр гарсан. Гэрээний дагуу бартаат замын 6 ширхэг мотоцикл, 3 ширхэг дроныг 2021 оны 10 дугаар сарын 17-ны өдөр, ОНБХЗ-д нийлүүлэх байгаль хамгаалагчийн майхан, хөнжил, гудас, байршил тогтоогч, дуран, зургийн аппарат тус бүр 6 ш, судалгааны камер, гал түймрийн тоног төхөөрөмжийн иж бүрдэл 3-ыг 2022 оны 02 дугаар сарын 28-ний өдөр тус тус хүлээлгэн өгсөн тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулж, сүүлийн санхүүжилтийг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр гаргасан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Түмэнхаан-Шалз ОНТХГ нь Онон Балжийн байгалийн цогцолборт газар, Тосон Хулстайн, Яхь нуурын болон Угтам уулын байгалийн нөөц газруудын хооронд биологийн олон янз байдлын шилжин нүүдэллэх, өсөн үржих таатай нөхцөлийг бүрдүүлсэн холбоос нутгийн загварыг бий болгох зорилго бүхий тус ажлын үр дүнгээс шалтгаалан төслийн II шатыг кластерийн хэмжээнд хэрэгжүүлэх нь үр дүнгүй гэсэн анд загвар төслийн туршлага, сургамжийг ашиглан, байгалийн нөөц, биологийн төрөл зүйлийн хамгаалал, зохистой ашиглалтыг хөгжүүлсэн бүс нутаг болгох нөхцөлийг бүрдүүлсэн. |
| | **3-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Үндэсний болон бүсийн түвшинд ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх | |
| | | **1. Байгаль хамгаалагчдын чуулган зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 4.01/:**<br>"Бид байгаль хамгаалагчид" үндэсний чуулганыг 2022 оны 03 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулсантай холбогдуулан тус арга хэмжээнд шаардлагатай *33,550,000.00 төгрөгийг* ХБНГУ-ын тусламжийн хөрөнгөөс санхүүжүүлсэн. Макс хотельс ХХК, Монголын байгаль хамгаалагчдын холбоо ТББ-уудтай гэрээ байгуулж байгаль хамгаалагчдын хурлын холбогдох зардлыг санхүүжүүлсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.** |

| | | |
|---|---|---|
| | **4-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:** Сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа | **2. Ойн тогтвортой менежментийн шалгуур үзүүлэлтэд мониторинг, үнэлгээ хийх ажлын хүрээнд /ҮАТ 4.02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/209 дугаартай тушаалаар 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр *40,000,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-1/1221 дугаартай гэрээг "Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ойн модны сургалт, судалгааны хүрээлэн"-тэй байгуулж ажилласны дүнд гүйцэтгэгч байгууллага нь ажлын эцсийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, тайланг хүлээн авах шийдвэрийг гаргуулсан. Гэрээний дагуу цахим тайлангуудыг хүргүүлсэн тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулж, сүүлийн санхүүжилтийг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр гаргасан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Энэхүү ажлын дүнд шалгуур үзүүлэлтүүдийг 2016 онд төслийн хүрээнд хийгдсэн суурь судалгаа болон түүнээс хойш хийгдсэн бүх үнэлгээний дүнтэй харьцуулан, дүгнэлт хийж, төслийн үр дүнг үнэлсэн ач холбогдолтой.<br><br>**3. Бэлчээрийн тогтвортой менежментийн шалгуур үзүүлэлтэд мониторинг, үнэлгээ хийх ажлын хүрээнд /ҮАТ 4.02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/58 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/210 дугаартай тушаалаар 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр *35,000,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-1/1321, 21/225 дугаартай гэрээг "Эко Ази" БОДС-тай байгуулж ажилласны дүнд гүйцэтгэгч байгууллага нь ажлын эцсийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, тайланг хүлээн авах шийдвэрийг гаргуулсан. Гэрээний дагуу цахим тайлангуудыг хүргүүлсэн тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулж, сүүлийн санхүүжилтийг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр гаргасан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**4. Биологийн олон янз байдлын загвар төслийн шалгуур үзүүлэлтэд мониторинг үнэлгээ хийх ажлын хүрээнд /ҮАТ 4.02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/48 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/197 дугаартай тушаалаар 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр *69,500,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-1/1421 дугаартай гэрээг "МУИС-ийн ШУС"-тэй байгуулж ажилласны дүнд гүйцэтгэгч байгууллага нь ажлын эцсийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, тайланг хүлээн авах шийдвэрийг гаргуулсан. Гэрээний дагуу цахим тайлангуудыг хүргүүлсэн тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулж, сүүлийн санхүүжилтийг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр гаргасан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хөдөлмөрийн зах зээл 2.6.4. Ажлын байрны мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргаж, хөдөлмөр* |

| | | |
|---|---|---|
| | **4-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа | *эрхлэлтийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах механизмыг бүрдүүлнэ*<br>*2.6.12. Гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн ханган нийлүүлэлтийн хэрэгцээг хангахад дотоодын ААН-үүдийг уялдуулан хөгжүүлэх Үндэсний ханган нийлүүлэлтийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. Хүн амын бүлэг бүрийн онцлогт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.*<br><br>**5. Нийгэм эдийн засгийн болон амьжиргааны түвшнийг тодорхойлох ажлын хүрээнд /ҮАТ 4.02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/50 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны “Гэрээ шууд байгуулах журам”-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/254 дугаартай тушаалаар 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр *66,475,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-01/1921 дугаартай гэрээг “Бодлого судлалын төв” ТББ-тай байгуулж ажилласны дүнд гүйцэтгэгч байгууллага нь ажлын эцсийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцүүлж, тайланг хүлээлгэн өгсөн тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулж, сүүлийн санхүүжилтийг 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр гаргасан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Судалгааны үр дүнд иргэдийн бодит орлого 2016 оноос 2021 онд 65% буюу 3.4 дахин өссөн нь орлогыг 20%-с доошгүй нэмэгдүүлэх төслийн шалгуур үзүүлэлтийг хангаж байна. Иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг төслөөс авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал орон нутгийн иргэд, захиргааны төлөөллийн зүгээс орчны бүсийн зээлийн эргэлтийн сангаас 2021 онд олгосон байгальд ээлтэй малчны нэн хөнгөлөлттэй зээл, ногоон тэжээл тарих, хадлан бэлтгэх трактор, тоног төхөөрөмж зэрэгт бодитой хөрөнгө оруулах үйл ажиллагаануудын орлогоос олох нэмэгдэл орлогыг тооцсон.<br><br>**6. Менежментийн үр ашигт байдлын шалгуур үзүүлэлтэд мониторинг үнэлгээ хийх ажлын хүрээнд /ҮАТ 4.02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/50 дугаартай тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны “Гэрээ шууд байгуулах журам”-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/253 дугаартай тушаалаар 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр *42,500,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-01/1821 дугаартай гэрээг “Газарзүй-геоэкологийн хүрээлэн”-тэй байгуулж ажилласны дүнд гүйцэтгэгч байгууллага нь ажлын эцсийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцүүлж, тайланг хүлээлгэн өгсөн тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулсан. Үлдэгдэл төлбөрийг 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр шилжүүлсэн. Судалгааны үр дүнд ТХГН-уудын хамгааллын үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээг 2016, 2018 оны түвшинтэй харьцуулахад 0.1-0.9 хувийн өсөлттэй буюу хамгааллын үнэт зүйлийн төлөв байдал сайжирсан үзүүлэлттэй байна. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**7. Хангайн бүсийн СМСТ-ийг компьютер тоног** |

| | | |
|---|---|---|
| | | **төхөөрөмжөөр хангах /ҮАТ 4.02/:**<br>Тус ажлыг "Дэд төслийн хүрээнд баригдсан ХЗ, СМТ, байгаль хамгаалагчийн байруудыг компьютер, тоног төхөөрөмжөөр хангах" /ҮАТ 2.01/-ын ажилтай нэгтгэн багцалж, БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/51 дугаартай "Хөрөнгө зарцуулах тухай" тушаалаар MON/ICB019/2019 дугаартай ажлын гэрээг "Ай Ти Зон" ХХК-тай 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдөр байгуулж ажилласны дүнд нийт *171,294,749.53 төгрөгийн* нийт 91 ширхэг тоног төхөөрөмжийг тус ХЗ-нд 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хүлээлгэж өгсөн тул гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%**<br>Энэхүү ажлын дүнд УТХГ-ын Хангайн бүсийн төвийг иж бүрэн тохижуулж, компьютер, тоног төхөөрөмжөөр хангаснаар тус бүсэд хамрагдах нийт 7 ХЗ-ны хамтын ажиллагаа сайжирч, байгаль хамгааллын чиглэлээрх сургалт, судалгаа, холбогдох бусад арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн. |
| | **4-р зорилтын хүрээнд:**<br>***Хүрэх үр дүн:***<br>Сургалт, бодлого, судалгааны хамтын ажиллагаа | **8. "ТХГН-ийн Хангайн бүсийн төвийн СМТ-ийн үзмэрийн танхим тохижуулах" ажлын хүрээнд /ҮАТ 4.02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/333 дугаартай тушаалаар 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр *299,395,348.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ҮТА № 06/2020 дугаартай гэрээг "Ворк мастер" ХХК-тай байгуулсан. Гэрээний дагуу бүсийн 7 хамгаалалтын захиргааны мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн санг боловсруулах, мэдээллийг электрон самбарт байршуулах, Хангайн бүсэд хамаардаг улсын тусгай хамгаалалттай холбогдох газруудын 3D макет хийх, биологийн төрөл зүйлийн хатаамал, чихмэлийг байршуулах шилэн хорго, үзмэрийн тавцанг бэлтгэх ажлыг хүлээн авах ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Хангайн нурууны БЦГ-ын ХЗ-нд ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр ажлыг хүлээн авахаар шийдвэрлэсэн. Үүрэг даалгаврын дагуу гүйцэтгэгч "Воркмастер" ХХК нь УТХГ-ын нэрс, мэдээллийг хянан сайжруулах, макетыг шинэчлэх зэрэг үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, ажлын хэсгийн 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн ажлын хэсгийн хурлаар хүлээн авсан тул ажлын гүйцэтгэлийн болон гэрээ дүгнэсэн актыг албажуулж, сүүлийн санхүүжилтийг 2022 оны 06 дүгээр сарын 30-ны өдөр гаргасан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Бүсийн төвийн тохижилтын ажлын хүрээнд бүсийн 7 хамгаалалтын захиргааны мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн санг боловсруулах, мэдээллийг электрон самбарт байршуулах, Хангайн бүсэд хамаардаг улсын тусгай хамгаалалттай холбогдох газруудын 3D макет хийх, биологийн төрөл зүйлийн хатаамал, чихмэлийг байршуулах шилэн хорго, үзмэрийн тавцанг бэлтгэхээс гадна тавилга, техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангана. Хангайн бүсийн төвийн үзмэрийн танхимыг бүрэн тохижуулснаар нийт 7 ХЗ-ны сургалт, сурталчилгааны үр ашиг нэмэгдэх, мэдээ, мэдээлэл сайжирна.<br><br>**9. Төслийн үр дүнг сурталчилсан богино хэмжээний баримтат нэвтрүүлэг хийх ажлын даалгавар боловсруулах, богино хэмжээний баримтат нэвтрүүлэг хийх /ҮАТ 4.03/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/335 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/12 |

| | | |
|---|---|---|
| | | дугаар тушаал 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр *81,600,000.00 төгрөгийн* дүн бүхий ҮТА № 06/2020 дугаартай гэрээг "Эрхэм Уул" ХХК-тай байгуулсан. Гэрээний дагуу төслийн I үе шатны ажлыг танилцуулах 15 минутын богино хэмжээний кино болон II/III үе шатны танилцуулга 5 минутын шторкны зохиолыг гаргаж, киног хийж ирүүлсэн. Гэрээт ажлын эцсийн тайланг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 09 дүгээр сарын 22-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. Тус ажлын хүрээнд хийсэн кино болон шторкыг төслийн хаалтын семинарын үеэр олон нийтэд танилцуулна. **Ажлын гүйцэтгэл 100%.** |
| | **Төслийн ерөнхий менежмент** | **1. "Төслийн 2021, 2022 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх" ажлын хүрээнд /PM01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/207 дугаартай тушаалаар "Төслийн 2021 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх" ажлын ҮАГ/АА 2021-171С дугаартай гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр "Интер аудит" ХХК-тай байгуулж ажилласны дагуу эцсийн тайланг 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн дотор хүлээн авсан. Аудитын тайланг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Германы сэргээн босголт зээлийн банк (KfW)-нд хүргүүлсэн. Аудитын зөвлөмжийн дагуу ХАА-г цахимжуулж, https://www.tender.gov.mn/mn/index/ хуудсаар зарлах зэрэг биелэлтийг гарган ажилласан. "Төслийн I, II дугаар шатны 2022 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх" ажлын ҮАТГ/АА-2022-191, ҮАТГ/АА-2022-192 тус тус дугаартай гэрээг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр байгуулсны дагуу шаардлагатай баримт бичиг, мэдээллээр ханган ажиллаж байна. Монгол Улсын сангийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/6683 дугаартай албан бичгийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 25-ны өдрүүдэд багтан дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**2. Төслийн I шатны Зөвлөх багийн автомашиныг БОАЖЯ/ТӨБЗГ-т хүлээлгэн өгөх, архивд төслийн материал хүлээлгэн өгөхтэй холбогдон гарах зардал /PM02/:**<br>Төслийн I шатны Зөвлөх багийн Ланд Круйзер 200 GXR автомашиныг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр БОАЖЯ-нд хүлээлгэн өгсөн. Төслийн I шатны санхүүгийн болон тендерийн түр хадгалах хадгаламжийн 326 нэгжийг 2022 оны 05 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд БОАЖЯ-ны архивд хүлээлгэн өгсөн. Байнга хадгалах хадгаламжийн холбогдох нэгжийг 2022 оны 12 дугаар сард багтаан Үндэсний төв архивд хүлээлгэн өгөхөөр архивын бэлтгэл ажлыг хангаж, 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 21/42 дугаартай ажлын гэрээг байгуулсны дагуу 2022 оны 12 дугаар сард архивлах бичиг баримтын жагсаалтыг хүргүүлсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.** |
| | **Бусад** | **Төслийн үйл ажиллагаанаас хэмнэгдсэн төсвийг Орчны бүсийн зээлийн эргэлтийн санд нэмж шилжүүлэх ажлын хүрээнд /Б01/:**<br>Төслийн I шат 2022 оны 12 дугаар сараар дуусгавар болсонтой холбогдуулан үйл ажиллагаанаас хэмнэгдсэн төсөв болох 255,172.34 еврог Орчны бүсийн зээлийн эргэлтийн санд шилжүүлэх тушаалыг 2022 оны 12 сард багтаан албажуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%.** |

| | | |
|---|---|---|
| | **ТХН болон Зөвлөх багийн зардал** | **1. Төсөл хэрэгжүүлэх зөвлөх багийн төлбөр /5.01/:**<br>2021 оны IV улирлын төслийн хэрэгжүүлэгч зөвлөх багийн төлбөрт нийт € 357,619.44 евро буюу 1,180,144,152.00 төгрөгийн санхүүжилтийг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр хийгдээд байна.<br><br>**2. Төслийн хаалтын арга хэмжээний хүрээнд /6.01/:**<br>Төслийн I шат 2022 оны 12 дугаар сараар дуусгавар болохтой холбогдуулан тус ажлыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/159 дугаартай "Хүүгийн орлогыг захиран зарцуулах тухай" тушаалаар хүүгийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу 2022 оны 12 дугаар сард багтаан нийт 250 албан хаагчдыг оролцуулан зохион байгуулахаар удирдамжийг гаргасан. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаартай "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолтой холбогдуулан тус ажил хойшилсон. |
| | **Тайлан** | **Хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах ажлын хүрээнд /R01/:**<br>Төслийн I болон II шатны үйл ажиллагааны тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хавсралтын дагуу 2021 оны эцсийн байдлаар, 2022 оны хагас жилийн байдлаар тус тус гаргаж, БОАЖЯ-ны ГХАХ-т 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 06/2022 дугаартай, 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 84/2022 дугаартай албан тоотоор тус тус хүргүүлсэн. Тайлангийн хувийг төслийн зөвлөх баг болон БОАЖЯ-ны ТХБНУГ-т илгээсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**Тусгай дансны татан авалт, зарцуулалтын тайланг KfW банкинд илгээх ажлын хүрээнд /R.02/:**<br>Төслийн II үе шатны татан авалтын тайланг БОАЖЯ болон Сангийн яамаар баталгаажуулан 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр болон 11 дүгээр сарын 10-ны өдөр ХБНГУ руу тус тус хүргүүлсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**Шилэн данс, ODAMIS, www.shilen-dans.mn, E-report, E-tailan-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээх ажлын хүрээнд /R.03/:**<br>Төслийн I, II шатны хяналт, шинжилгээ үнэлгээний тайланг "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"-ын хавсралтын дагуу 2021 оны эцсийн байдлаар гаргаж, Сангийн яамны https://odamis.mof.gov.mn цахим хуудсанд 2022 оны 03 дугаар сард байршуулсан.<br>НӨАТ-ын тайланг цаасаар болон цахим хэлбэрээр сар бүр хийж Татварын ерөнхий газарт хүргүүлж байна.<br>Шилэн дансны тайлан мэдээг сар бүр шинэчлэн хийж, БОАЖЯ-ны дотоод аудит хяналт үнэлгээний газарт улирал бүр нэгтгэн цахимаар илгээж ажилласан. **Ажлын гүйцэтгэл 100%** |
| 7 | | **Ололт, амжилт:**<br>• 2022 он төслийн хувьд I үе шат дуусаж, II, III шатны үйл ажиллагаа давхцаж байгаагаараа онцлог, ТХН-ийн хувьд хоёр үе шатыг зэрэг хэрэгжүүлж байгаа нь нэгжийн ажилтнуудад ажлын ачаалал, үүрэг хариуцлага нэмэгдсэн жил байсан хэдий ч, 2022 оны үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж дууссан. Жилийн эцсийн байдлаар төслийн нийт зарцуулалт өссөн дүнгээрэ |

<table>
<tr><td></td><td>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</td><td>11,5 евро буюу нийт зарцуулалтын 100% байна.<br><ul><li>KfW банкны үнэлгээний баг 2022 оны 05 дугаар сарын 02-10-ны өдрүүдэд Монголд ирж ажиллах үеэр төслийн I шатны Буцалтгүй тусламжаас хэмнэгдсэн зарцуулагдаагүй үлдэгдлийг Орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих зээлийн эргэлтийн санд шилжүүлэхээр санхүүжүүлэгч байгууллагатай зөвшилцөөнд хүрсэн.</li><li>Монгол талаас оруулах хөрөнгө оруулалтын хүрээнд I шатны хэрэгжүүлэлтэд Тусгай гэрээнд 6.65 сая төгрөгийг монголын талаас оруулна гэж тооцсон байснаас ойролцоогоор 8.6 тэрбум төгрөгийг оруулсан. Дээрх тоо нь төлөвлөсөн хөрөнгө оруулалтаас даруй 2 сая төгрөгөөр илүү гарсан байна. ТХН-тэй холбоотой зардал, мөн тусгай хамгаалалттай газар нутаг дахь ашиглалт, засвар үйлчилгээ (АЗҮ) хийхэд Монголын талын хөрөнгө оруулалтыг ашигласан. Энэхүү амжилтад нь санхүүжүүлэгч байгууллагаас БОАЖЯ болон СЯ-ыг амжилттай ажилласан гэж үнэлсэн.</li><li>Дүгнэж хэлэхэд, I үе шатанд ТХГН-ыг дэмжих хөрөнгө оруулалт нь ТХГН-ийн удирдлагын чадавхыг сайжруулах, улмаар урт хугацаанд биологийн олон янз байдлын хамгаалалтыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоо сайн биелүүлсэн гэж санхүүжүүлэгч байгууллага дүгнэсэн.</li></ul>Цаашид анхаарах асуудлууд, дутагдал:<ul><li>Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор төслөөс хийж буй томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгууламжтай холбоотой засвар үйлчилгээ, урсгал зардлыг тусгай хамгаалалттай газруудын төсөвт жил бүр суулгаж, төслөөс хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагааг төсөл дууссаны дараа монголын тал буюу төсөл хэрэгжүүлэгчид бие даан авч явах нөхцөлийг бүрдүүлэх, төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах</li></ul></td></tr>
<tr><td>8</td><td>Төслийг хэрэгжүүлэгч талуудын х/а-нд өгөх хөндлөнгийн үнэлгээ</td><td>Төслийн үйл ажиллагааг үнэлэх KFW банкны үнэлгээний баг жил бүр ирж ажилладаг. 2022 онд KFW банкны төслийн явцын үнэлгээний баг 2022 оны 05 дугаар сарын 01-09-ний өдрүүдэд Монголд ирж ажиллан, төслийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийсэн.</td></tr>
<tr><td>9</td><td>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)</td><td><table>
<tr><td rowspan="3">Биелэлт дундаж %</td><td>Менежмент</td><td>Зорилт 1</td><td>Зорилт 2</td><td>Зорилт 3</td><td>Зорилт 4</td><td>Бусад</td></tr>
<tr><td>100%</td><td>100%</td><td>100%</td><td>100%</td><td>100%</td><td>100%</td></tr>
<tr><td>Нийт 2 ажил<br>2 ажил-100%</td><td>Нийт 1 ажил<br>1 ажил-100%</td><td>Нийт 13 ажил<br>13 ажил-100%</td><td>Нийт 4 ажил<br>3 ажил- 100%,<br>1 ажил-<br>цуцлагдсан</td><td>Нийт 9 ажил<br>9 ажил-100%</td><td>Нийт 1 ажил<br>1 ажил- 100%</td></tr>
</table>
2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт 47 ажил төлөвлөсөн.<br>Үүнээс: 1 ажил үнэлээгүй. Үүнд:</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | ТХГН-ийн ХЗ-дын зарим үйл ажиллагааг цахимжуулах ажлыг БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 03/3181 дугаартай албан бичгээр захиалагч талаас цуцалсан.<br>**Үнэлсэн:** Нийт **29 ажил.**<br>100%-тай=29=*2900 /бүрэн хэрэгжиж дууссан/* |
| | | **Төслийн I шатны үйл ажиллагааны хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 100%-ийн биелэлттэй байна.** |
| 10 | **ЗГХЭГ-ын үнэлгээ** | Нэгдсэн үнэлгээ |
| | | ... % |

| Нэмэлт мэдээлэл /сая төгрөгөөр/ | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | **Зарцуу лалт** | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
| | **ХБНГУ-ын Засгийн газар** | 452.81₮ | 1,763.54₮ | 5,415.49₮ | 5,864.21₮ | 4,728.84₮ | 6,172.75₮ | 7,205.70₮ | 8,596,27₮ |
| | **МУ-ын Засгийн газар** | 482.16₮ | 465.98₮ | 544.07₮ | 492.15₮ | 383.50₮ | 514.10₮ | | |
| 12 | **Жендерийн мэдээлэл** | Тус төслийн хүрээнд байгаль орчин, нийгмийн нөлөөллийг байгуулж буй гэрээ болгонд тусган ажилладаг болно. | | | | | | | |
| 13 | **Суурь судал гаа хийгд сэн эсэх** | 2022 онд хийгдээгүй (УТХГ-ын МҮАБ-ын суурь үнэлгээ, БОЯБ, ой, бэлчээр, нийгэм эдийн засгийн суурь судалгаанууд 2015-2016 онуудад хийгдсэн.) | | | | | | | |

ХЯНАСАН:

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Г.ЭРДЭНЭБАЯСГАЛАН

БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН Ц.ЭНХСАЙХАН

## БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН-2022.12.31

*Төгрөгөөр/еврогоор*

| | Тайлант хугацаанд 2022.12.31 | | Өссөн дүнгээр | |
|---|---|---|---|---|
| **Орлого** | **Евро** | **Төгрөг** | **Евро** | **Төгрөг** |
| KfW | | | | |
| Шууд санхүүжилт(Зөвлөх) | 177,264.19 | 573,449,654.65 | 1,749,682.41 | 5,948,920,194.00 |
| Хялбаршуулсан шууд төлбөр | - | | 1,451,478.35 | 4,856,094,997.33 |
| Татан төвлөрүүлэлтийн данс | 353,324.96 | 1,155,961,422.85 | 8,277,411.34 | 28,143,198,556.00 |
| KfW-орсон нийт санхүүжилт | **530,589.15** | **1,729,411,077.50** | **11,478,572.10** | **38,948,213,747.33** |
| Хүүгийн орлого | | | | |
| МУЗГ | 382,098.71 | 1,400,701,280.00 | | |
| Төрийн сан | - | - | 957,123.98 | 2,508,523,700.00 |
| **Нийт санхүүжилт/Орлого** | **912,687.86** | **3,130,112,357.50** | **957,123.98** | **2,508,523,700.00** |
| Зардал | | | | |
| KfW | 999,748.88 | 3,668,098,635.70 | 11,292,035.59 | 38,392,921,006.00 |
| МУЗГ | 382,098.71 | 1,400,701,280.00 | 1,292,501.45 | 4,394,504,930.00 |
| МУЗГ-т буцаан шилжүүлсэн | | | 46,721.24 | 140,674,401.30 |
| Гадаад ханшийн зөрүү | | (2,288,090,556.43) | | (2,288,090,556.43) |
| **Нийт зардал** | **1,381,847.59** | **2,780,709,359.27** | **12,631,258.28** | **40,640,009,780.87** |
| Үр дүн | 469,159.73 | 1,642,059,055.00 | 255,172.34 | 936,232,418.91 |
| Урьдчилгаа | | | - | |
| **Цэвэр мөнгөн хөрөнгө** | **724,332.07** | **2,538,428,982.64** | **-** | **-** |
| Эхний үлдэгдэл | | | | |
| KfW | | | | |
| Тусгай данс | 724,332.07 | 2,538,428,982.64 | | |
| Дэд данс | | | | |
| **KfW-ийн нийлбэр** | **-** | **-** | | |
| МУЗГ | | | | |
| Төрийн сан | | | | |
| **Эхний үлдэгдлийн нийлбэр** | **-** | **2,538,428,982.64** | | |
| **Эцсийн үлдэгдэл** | **255,172.34** | **822,417,900.10** | **747,928.88** | **2,744,166,019.30** |
| KfW | | | | |
| Тусгай данс | 255,172.34 | 822,417,900.10 | 747,928.88 | 2,744,166,019.30 |
| Дэд данс | | | | |
| **KfW-ийн эцсийн үлдэгдлийн нийлбэр** | **255,172.34** | **822,417,900.10** | **747,928.88** | **2,744,166,019.30** |
| МУЗГ | | | | |
| Төрийн сан | | | | |
| **Эцсийн үлдэгдлийн нийлбэр** | **255,172.34** | **936,232,418.91** | **747,928.88** | **2,744,166,019.30** |

Тусгай лансны ханш орлого орж ирсэн өдрийн монгол банкны албан ханшаар

Дэд дансны ханш нь тусгай данснаас шилжүүлэг хийсэн өдрийн арилжааны банкны ханшаар

МУГЗ-ын санхүүжилт орж ирсэн өдөр болгоны монгол банкны албан ханшаар

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын хүснэгт 5

**БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ II/III ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
(2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

| № | Төслийн агуулга | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1 | **Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар** | **Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II/III төсөл**<br>**Шийдвэр:**<br>**БОЯБХУАӨДЗ II төсөл:** Монгол-Германы Засгийн газар хооронд 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр<br>**БОЯБХУАӨДЗ III төсөл:** Монгол-Германы Засгийн газар хооронд 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр<br>**Төслийн дугаар: BMZ 2016 67 054; BMZ 2018 68 272**<br>**Төслийн зорилго:** Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн болон нийлмэл/ холбоос нутгуудын (орчны бүс болон экологийн коридор, кластер) тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино. |
| 2 | **Санхүүжилтийн эх үүсвэр** | ХБНГУ-ын Засгийн газар - **Буцалтгүй тусламж**<br>Монгол Улсын Засгийн газар |
| 3 | **Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа** | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОАЖЯ, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх баг |
| | | Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, БОАЖЯ-ны ТХБНУГ, ТХГН-ийн хамгаалалтын захиргаад |
| | | Хэрэгжих хугацаа: 6 жил: 2020.03.02 - 2026 /II, III үе шат/ |
| 4 | **Төсөл, хөтөлбөрийн зорилтууд** | **Зорилт 1:** Улсын хэмжээний ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэглэлээр хангах;<br>**Зорилт 2:** Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу Кластер нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;<br>**Зорилт 3:** Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон ТХГ-ыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;<br>**Зорилт 4:** ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | **Зардал** | **Төсөв (Нийт зардал)** | Төслийн II үе шатны нийт төсөв 32.8 сая евро.<br>ХБНГУ-ын Засгийн газар 27.5 сая евро,<br>Монгол Улсын Засгийн Газар 14.8 тэрбум төгрөг | | | |
| | | **Үүнд:** | Төсөв (2022 он) | Гүйцэтгэл | | Хувь |
| | | **ХБНГУ-ын Засгийн газар** | 6,883,600.00.0 төгрөг | 1,806,082.85 евро | 6,626,554,130.00 төгрөг | 96.3% |
| | | **МУ-ын Засгийн газар** | 852,962,000.0 төгрөг | 213,884.59 евро | 748,596,068.53 төгрөг | 92,0 % |
| 6 | **Төсөл, хөтөлбөрийн зорилт:** | | 2022 оны Үйл ажиллагааны /2022.06.17-ны өдөр/ шинэчилсэн төлөвлөгөөний дагуу биелэлтийг гаргав. | | | |
| | | **1-р зорилтын хүрээнд:**<br>***Хүрэх үр дүн:***<br>ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах | *Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.2. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.*<br>*6.2.2. Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэх, шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ.*<br><br>**1. Биологийн олон янз байдлын суурь судалгааны зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 1.01./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/58 дугаартай тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/280 дугаартай тушаалын дагуу 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр 268,980,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий БОЯБХУАӨДЗТөсөл/202202010, 22/177 дугаартай гэрээг "Монгол Улсын Их сургууль"-тай 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр байгуулж ажилласны дагуу судалгааны ажлын 5 баг баруун аймгуудад 09 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл ажиллан, тайланг боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсний дагуу төслийн дэргэд дэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>Судалгааны үр дүнд УТХГ болон ОНТХГ-уудад (5 кластерт 5 зүйлийн БОЯБ) түлхүүр зүйлүүд нь Кластер 1, 2: Цоохор ирвэс Snow leopard, Аргаль хонь, Кластер 3: Халиун буга, Бор гөрөөс, Кластер 4: Бөхөн, Хар сүүлт, Аргаль хонь, Кластер 5: Хулан адуу, Тахь адуу-, Хар сүүлтийн тархалт, нөөц, сүргийн бүтэц, нүүдэл шилжилт хөдөлгөөн (эко коридор) нутгуудыг тодорхойлох талаарх суурь мэдээллийг бүрдүүлсэн.<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин*<br>*2.5.8. Агаар болон орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр болон хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.* | | | |

| | | |
|---|---|---|
| | **1-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах | **2. Бэлчээрийн тогтвортой менежментийн (4 аймгийн 10 суманд) суурь судалгааны зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /YAT 1.02./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/58 дугаар тушаалаар байгуулсны дагуу тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/07 дугаартай тушаалаар 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр “Ховд Их сургууль”-тай 125,820,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий дугаартай №ЗСШ-02/122, 22/48 гэрээг ажилласны дагуу судалгааны ажлын баг 4 аймгийн 10 суманд бэлчээрийн судалгааг хийсэн бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр төслийн дэргэд дэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулсан. Үлдэгдэл төлбөрийг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр шийдвэрлэсэн. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>Судалгааны үр дүнд Увс аймгийн Тариалан, Бөхмөрөн сумд, Ховд аймгийн Цэцэг сум, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум, Увс аймгийн Тэс, Зүүнхангай сумд, Ховд аймгийн Дөргөн, Буянт сумд, Говь-Алтай аймгийн Бугат сум, Ховд аймгийн Алтай суманд ТХГН-үүдын хамгааллын үнэт зүйлийн төлөв байдлын үнэлгээг 2016, 2018 оны түвшинтэй харьцуулахад 0.1-0.9 хувийн өсөлттэй буюу хамгааллын үнэт зүйлийн төлөв байдал сайжирсан үзүүлэлттэй байна.<br><br>**3. ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын суурь судалгааны зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /YAT 1.03./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/253 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/18 дугаартай тушаалаар 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр “Эко Ази дээд сургууль”-тай *70,400,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий 02/0821 дугаартай гэрээг байгуулж ажилласны дагуу гүйцэтгэгч нь эцсийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулсан. Үлдэгдэл төлбөрийг 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%**<br>Улсын тусгай хамгаалалттай 22 газар, орон нутгийн тусгай хамгаалалттай 1 газар ажиллаж, төсөлд хамрагдсан ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын суурь мэдээллийг бүрдүүлсэн болно.<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.2.Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.*<br>*6.1.3. Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдлыг үнэлнэ.* |

| | | |
|---|---|---|
| | 1-р зорилтын хүрээнд: **Хүрэх үр дүн:** ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах | **4. Ойн тогтвортой менежментийн суурь судалгааны зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 1.04./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/153 дугаартай тушаалаар 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр "ШУТИС-ийн ой модны сургалт, судалгааны хүрээлэн"-тэй *45,000,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ГШБ-2/1621, 21/194 дугаартай гэрээг байгуулсны дагуу гүйцэтгэгч нь эцсийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үүрэг даалгаврын биелэлтээр тус ажлыг хүлээн авахаар шийдвэр гарсан. 2022 оны 01 дүгээр сард эцсийн тайланг хүлээн авснаар 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр үлдэгдэл санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Энэхүү ажил хийгдсэнээр Кластерт хамрагдсан баруун 3 аймгийн 10 суманд ойн тогтвортой мэдээллүүдийн суурь үзүүлэлтийг бүрдүүлсэн болно.<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Гэр бүл*<br>*2.3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ.*<br>*2.4.10. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ.*<br><br>**5. Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааны зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 1.05./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/314 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсан бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/450, 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/463 дугаартай тушаалаар үнэлгээний хорооны гишүүнийг шинэчилсэн. Тус тендерийг KfW банкны Хязгаарлагдмал өрсөлдөөнт тендерийн журмын дагуу зохион байгуулахаар 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зарласан. Тендер хүлээн авах хугацаа буюу 09 дүгээр сарын 30-ны өдөр ирсэн тендерүүдийг Үнэлгээний хороо үнэлэн, тендерийн баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй мөн техникийн саналууд нь үндсэн шаардлага (авбал зохих доод оноог авах)-ыг хангаагүй тул ирсэн бүх тендерээс татгалзан, тус тендер амжилтгүй болсон. Тендерт оролцогч нарт 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 03/6665 тоот албан бичгээр ирүүлсэн тендерээс татгалзаж байгааг мэдэгдсэн. Үнэлгээний хороо ажлын даалгаврын хугацаа болон төсвийг өөрчлөн шинэчлэн боловсруулж, санхүүжүүлэгч байгууллагад илгээн, зөвшөөрлийг хүлээж байна. Тус тендерийг 2023 оны эхний улиралд багтаан дахин зарлана. **Ажлын гүйцэтгэл 30%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин*<br>*2.5.2. Орон сууцны чанар, стандартыг хангаж, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.* |

| | | |
|---|---|---|
| | | *2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.*<br>*2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.*<br><br>**6. Төслийн хүрээнд баригдах барилгуудын зураг төсөл, ажлын гүйцэтгэл, чанарт инженерийн хяналт тавих багийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 1.06./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/279 дугаар тушаалаар БОЯБХУАӨДЗТөсөл/202202013, 22/178 дугаартай 330,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг "Некст степ инженеринг" ХХК-тай 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээт ажлыг 2022 оны 08 дугаар сарын 01 өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэнэ.<br>Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага эхлэлийн тайлан, Хустайн БЦГ-ын ХЗ-ны байгаль хамгаалагч, судлаачдын байрны засварын ажлын даалгавар, 2 удаагийн хяналт тавьсан тайланг ирүүлсний дагуу гүйцэтгэгчийн эхний санхүүжилтийг 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр шийдвэрлэсэн. **Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 100%** /2025.10 сард дуусах шатчилсан гэрээ/<br><br>**7. Байгаль хамгаалагчийн байр болон хөдөлгөөнт хяналтын постын барилгын ажлын зураг, төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 1.07./:**<br>Байгаль хамгаалагчийн байр болон хөдөлгөөнт хяналтын постын барилгын ажлын зураг, төсөв боловсруулах талаар уулзалтыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр БОАЖЯ-ны ТХБНУГ-ын төлөөллийг байлцуулан зохион байгуулсны дагуу захиалагч талаас 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 09/4585 дугаартай албан бичгээр ажлын даалгаварт тавих шаардлагыг хүлээн авсан. Төслийн хүрээнд Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчийн байрны зураг төслийг 2017 онд боловсруулсан "Бадмаараг төсөл" ХХК нь тус зураг төслийг шинэчлэн боловсруулахаас татгалзсан учир шинээр гүйцэтгэгч сонгон шалгаруулах, төсөвт өртгийг нэмэгдүүлэх шаардлага үүсээд гарсан. Тус ажил Баруун бүсийн СМТ болон бусад барилгын зургийн ажилтай хамт хийхээр төслийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан. **Ажлын гүйцэтгэл 0%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгаалалтын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.*<br><br>**8. Төсөлд хамрагдсан байгаль орчны байгууллагууд, бусад ТХГ-ын ХЗ-дыг шаардлагатай судалгааны багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 1.08./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/228 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсан. 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулагдсан Төслийн удирдах хорооны хурлаар тус тендер шалгаруулалтыг 2 багц болгон зарлах, мөн төсөвт өртөгт |
| | **1-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах | |

| | | |
|---|---|---|
| | **1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:** ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах | өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсний дагуу ажлын даалгаврын төслийг 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр эцэслэсэн.<br>Багц 1:“Судалгааны тоног төхөөрөмж”: БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/475 дугаар тушаалаар дугаартай 691,982.86 еврогийн үнийн дүн бүхий MONICB-02/0321, №22/290 дугаартай гэрээг “АЧСВС” ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсны дагуу чиг үүрэг бүхий байгууллагуудын мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын хэрэгцээ шаардлагыг хангасан 14 төрлийн багаж тоног төхөөрөмжийг 2023 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн дотор хүлээн авахаар ажиллаж байна.<br>Багц 2: “Цаг уурын автомат станц”: БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/462 дугаар тушаалаар дугаартай 104,396.00 еврогийн үнийн дүн бүхий MONICB-02/0321 дугаартай гэрээг “АЧСВС” ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсны дагуу төсөл хэрэгжиж буй аймгуудын Ус цаг уур орчны шинжилгээний төвд өндөр хүчин чадал бүхий цаг уур, орчны шинжилгээний 4 автомат станц нэмж суурилуулах тус ажлын гүйцэтгэлийг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүлээн авахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 100%.** /2022 онд гэрээг байгуулсан байх, 2023.06 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./ Тус ажлын үр дүнд байгаль орчны судалгаа, сургалтын чанарыг сайжруулах, мэргэжилтэн, байгалв хамгаалагч нарын чадавхыг бэхжүүлэх болон цаг уурын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зарлан мэдээлэх, цаг алдалгүй арга хэмжээ авах ажлыг сайжруулах зорилготой.<br><br>**9. Төсөлд хамрагдсан байгаль орчны байгууллагууд, бусад ТХГ-ын ХЗ-дыг шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 1.09./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/228 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороог шинэчлэн байгуулсан. БОАЖ-ын сайдын 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/176 дугаар тушаалаар ТХГН-ийн Хамгаалалтын захиргаанд зайлшгүй байх үндсэн багаж хэрэгслийн стандартыг батлуулсны дагуу ажлын даалгаврыг хэлэлцэх уулзалтыг 2022 оны 09 дүгээр сарын 22-ны болон 27-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, эцэслэсэн. Тус тендерийг KfW банкны Үндэсний тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулахаар тендерийг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зарлан, 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр нээсний дагуу үнэлгээ хийгдэж байна. Тус ажлын гэрээг 2023 оны 01 дүгээр сард байгуулж, 07 сард хүлээн авахаар төлөвлөсөн. **Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 100%.** /2022 онд тендерийг зарласан байх, 2023.07 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>**10. Төсөлд хамрагдсан сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчид болон бусад ТХГН-ийн ХЗ-дын ажилтнуудыг 4 улирлын дүрэмт (919) хувцсаар хангах /ҮАТ 1.10./:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/426 дугаартай тушаалаар Тендерийн үнэлгээний хороог байгуулсан бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/440 дугаартай тушаалаар үнэлгээний хорооны гишүүнийг шинэчилсэн. БОАЖ-ын сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/456 дугаар тушаалаар ТХГН-ийн байгаль |

| | | |
|---|---|---|
| | **1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:** ТХГН-ийн сүлжээний менежментийн төлөвлөлтийг сайжруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах | хамгаалагчдыг өвөл, зуны дүрэмт хувцасны стандартыг шинэчлэн батлуулсны дагуу ажлын даалгаврыг хэлэлцэх уулзалтыг 2022 оны 10 дугаар сарын 26-ны болон 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, эцэслэсэн. Сонгон шалгаруулалтыг KfW банкны Үндэсний тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулсны дагуу БОАЖЯ-ын ТНБД-ын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/562 дугаар тушаалаар 694,640 евро үнийн дүн бүхий MONNCB-04/22, 22/373 дугаартай гэрээг "Хилийн 0288 дугаар анги" ТӨААТҮГ-тай 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан. Ажлын гүйцэтгэлийг 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн дотор хүлээн авахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 100%.** /2022 онд гэрээ байгуулсан байх, 2023.06 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br>Ажлын үр дүнд төсөлд хамрагдсан сумдын БХ, БО-ны хяналтын улсын байцаагчид болон бусад ТХГН-ийн ХЗ-дын 919 ажилтнуудыг оффисын болон хээрийн ажлын зориулалт бүхий 4 улирлын 17 нэр төрлийн иж бүрэн дүрэмт хувцсаар хангасан байна. |
| | **2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:** Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | *Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.*<br><br>**1. Кластерт хамрагдсан байгаль орчны байгууллагуудад бартаат замын (18) автомашин нийлүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 2.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/08 дугаар тушаалаар MONICB-03/2020 дугаартай € 629,025.52 үнийн дүн бүхий гэрээг "Таван Богд" ХХК-тай 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдөр байгуулж ажилласны дагуу LC76, LC79, LC300 загварын нийт 18 ширхэг машиныг БОАЖЯ (1), Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор (5) аймгийн БОАЖГ, Хар Ус нуурын УТХГН, Говийн их дархан цаазат газрын Б хэсэг, Мянган угалзатын нурууны БЦГ, Хомын талын БЦГ, Увс нуурын ай савын УТХГН, Хан хөхийн нурууны УТХГН, Говийн их дархан цаазат газрын А хэсэг, Хөх сэрхийн нурууны УТХГН, Монгол Алтайн нурууны УТХГН, Мөнххайрханы нурууны УТХГН (10) хамгаалалтын захиргаа, Хар нуур-Ховд голын сав газар, Үенч, Бодонч, Булган голын (2) сав газрын захиргаа зэрэг байгаль орчны 18 байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр ёслолын үйл ажиллагаагаар хүлээлгэн өгсөн.<br>2022 оны 08 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд 18 байгууллагын удирдах ажилтан болон жолооч нарт "Техник тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, тээвэрлэлт, ачилт буулгалт, ашиглалтын бүхий л үе шатуудад мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй"-н сургалтыг танхимын болон дадлага хэлбэрээр зохион байгуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Энэхүү ажлын дүнд Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын арга хэмжээ сайжирч, байгаль орчны хяналт мониторингийн чадавх сайжруулахад бодит дэмжлэг боллоо. |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | **2. Хан Хэнтийн УТХГ-т бартаат замын (1) автомашин нийлүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 2.02/:**<br>Тус ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн төслийн Удирдах хорооны хурлаар хэлэлцэж, “Кластерт хамрагдсан байгаль орчны байгууллагуудад бартаат замын автомашин нийлүүлэх, хүргэх” №MONICB-03/2020 тендерт шалгарсан “Таван Богд” ХХК-тай 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хийсэн гэрээний үнийг 5,8 хувиар өсгөн нэмэлтээр нэг ширхэг бартаат замын автомашин (LC-76) худалдан авахаар шийдвэрлэсэн.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр А/132 дугаар тушаалаар MONICB-03/2020 дугаартай гэрээнд бартаат замын нэг автомашин нэмэх нэмэлт, өөрчлөлтийг 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр албажуулсны дагуу . УТХГ-ын Хан Хэнтийн ХЗ-нд 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүлээлгэн өгсөн тул гэрээ дүгнэсэн актыг албажуулж, үлдэгдэл санхүүжилтийг 12 дугаар сарын 06-ны өдөр олгоод байна. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**3. Баруун бүсийн ССМТ-ийн хэрэгцээт байдлын судалгааны ажлын хүрээнд /ҮАТ 2.03/:**<br>БОАЖЯ-ны сайдын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын бүтэц орон тоо болон сургалт, мэдээллийн төвүүдийн байршлыг шинэчлэн баталсны дагуу Хангайн бүсийн төвийг Архангай аймагт, Баруун бүсийн төвийг Ховд аймгийн Жаргалант суманд барьж байгуулахаар тогтсон байдаг.<br>Үүнтэй холбогдуулан Ховд аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/149 дүгээр захирамжаар байгуулагдсан ББССМТ-ийн барилгын зураг төслийн ажлын даалгавар боловсруулах, зураг төслийн ажилд хяналт тавих ажлын хэсгийг байгуулсан.төслийн зөвлөх баг 2022 оны 10 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Ховд аймагт ажиллаж, шинээр томилогдсон Засаг даргатай тус асуудлыг хэлэлцсэнээр Баруун бүсийн ССМТ-ийн хэрэгцээт байдлын судалгааг төслийн зөвлөх багаас хийхээр шийдсэний дагуу доктор А.Намхайг богино хугацааны зөвлөхөөр ажиллуулсан. Гэрээний дагуу зөвлөх нь Архангай болон Ховд аймгуудад ажиллан, төслийн хүрээнд баригдсан Хангайн бүсийн төвийн барилгын үр дүн, ашиглалттай танилцан, Ховд аймагт холбогдох уулзалт, хэлэлцээ хийж эцсийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр хүлээлгэн өгсөн. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**4. Баруун бүсийн ССМТ-ийн барилгын хөрсний геологи, геодезийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, барилгын ажлын зураг, төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 2.04/:**<br>Тус ажил төслийн “Баруун бүсийн ССМТ-ийн хэрэгцээт байдлын судалгаа”-ны /ҮАТ 2.03/ эцсийн тайланг 2022 оны 12 дугаар сард хүлээн авсантай холбогдуулан тус ажлын үр дүнд суурилан хийгдэх байсан тул 2023 онд хийгдэхээр төлөвлөгдсөн. **Ажлын гүйцэтгэл 0%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин*<br>*2.5.20. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний* |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | *аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад хүргэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.*<br><br>**5. Кластеруудын хэмжээнд нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 2.05/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/170 дугаартай тушаалаар *689,111,180.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ҮТБ-№02/0621 дугаартай гэрээг "Мөнх ногоон тал" ХХК-тай 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсны дагуу төслийн 5 кластерын хэмжээнд нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор гурван улирлын иж бүрэн хүлэмж 22, бага оврын услалтын иж бүрэн систем 62-ыг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хүлээн авсан. Тоног төхөөрөмжийн түгээлтийг гэрээний дагуу Хар ус нуурын УТХГ, Увс нуурын ай сав газар, Хан Хөхийн нурууны УТХГ, Говийн их ДЦГ-ын “А” болон “Б” хэсэг, Мөнххайрхан, Мянган угалзатын нурууны БЦГ, нийт 7 ХЗ-ны Орчны бүсийн иргэдэд 2022 оны 06 дугаар сард багтаан нийлүүлж дуусгасан. **Ажлын гүйцэтгэл 100%**.<br>УТХГ-ын ОБ-ийн иргэдийн амьжиргааг сайжруулах зорилготой энэхүү ажлын дүнд давхардаагүй тоогоор Баянхонгор, Говь-алтай, Ховд, Баян-Өлгий, Увс 5 аймгийн 28 суманд 70 төсөл санаачлагч нарт дэмжлэг үзүүлсэн.<br><br>**6. ТХГН-ийн ОБ-ийн сумдын сургуулийн эко кабинет тохижуулах, эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох /ҮАТ 2.06/:**<br>Зорилтот аймгуудын орчны бүсийн орон нутгийн иргэдэд өндөр чанартай, түргэн шуурхай, эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг үзүүлэх зорилготой энэхүү арга хэмжээ нь орчны бүсийн эрүүл мэндийн салбарын чадавхыг сайжруулах, нэмэгдүүлэх, улмаар төслийн зорилтот сумдад орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн анхан шатны яаралтай тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад чухал дэмжлэг төслийн 2, 3-р үе шатанд хамрагдсан 11 аймгийн ЭМГ-аас урьдчилсан тандах судалгааг хийсний дагуу 7 аймгийн 17 сумыг хамруулах хэрэгцээ шаардлага байгаа нь тодорхойлогдсон. Үүнд: Дорнод-1, Дундговь-1, Баянхонгор-3, Говь-Алтай-4, Ховд-3, Увс-3, Сүхбаатар-2 суманд түргэн тусламжийн машины парк ашиглалтын хугацаа дууссан солих хэрэгцээ шаардлага үүссэн байна. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**7. ТХГН-ийн ОБ-ийн сумдад тогтвортой амьжиргааг дэмжих хэрэгцээ шаардлагыг тодорхойлох /ҮАТ 2.07/:**<br>Төсөлд хамрагдсан бүс нутгийн нийгэм эдийн засгийн суурь судалгааны ажил хийхээр төлөвлөснийг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Төслийн удирдах хорооны хурлаар хэлэлцэж, цуцалсан бөгөөд төслийн бүс нутагт орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих бодлогыг тодорхойлсон баримт бичиг - “ТХГН-ийн орчны бүсийн иргэдийн амьжиргаа дэмжих үзэл баримтлал”-ыг төслийн Зөвлөх баг, ТХН хамтран боловсруулж KfW банкаар батлуулсан. Энэ үзэл баримтлалд тусгагдсан үндсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж эхлэх зорилгоор төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсэгт хамрагдсан 7, баруун бүсийн 10, нийт 17 ТХГН-ийн ОБ-ийн сумдад орон нутгийн иргэдийн экологийн боловсрол мэдлэг мэдээллийг сайжруулахад туслах зорилгоор |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>Хүрэх үр дүн: Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | сумдын сургуулиудад Эко-кабинет байгуулах, сумдад эмнэлгийн түргэн тусламжийн орчин үеийн туулах чадвар сайтай авто машин нийлүүлэх хэрэгцээ шаардлагын судалгааг хийсэн. Мөн Орчны Бүсийн Эргэлтийн Сангийн бага хүүтэй зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой сумдыг сонгох үнэлгээний судалгаа хийж 22 сумыг сонгон авч үйл ажиллагааг эхлүүлэхэд бэлэн болсон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.*<br><br>**8. Баруун бүсийн ТХГН-ийн ХЗ-дын ажилтнуудыг 4 улирлын дүрэмт (240) хувцсаар хангах /ҮАТ 2.08/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/485 дугаар тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог байгуулсан бөгөөд 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/07, 08 дугаар сарын 04-ний А/146, 11 дүгээр сарын 04-ний А/231 дугаартай болон 2022 оны 03 дугаар 10-ны А/72 дугаартай тушаалаар үнэлгээний хорооны гишүүнийг тус тус шинэчилсэн. Сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсны дагуу БОАЖЯ-ын ТНБД-ын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/277 дугаар тушаалаар 653,540,250 төгрөгийн үнийн дүн бүхий БОЯБХУАӨДЗТөсөл202202004, 22/164 дугаартай гэрээг “Хилийн 0288 дугаар анги” ТӨААТҮГ-тай 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан. БОАЖ-ын сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/456 дугаар тушаалаар ТХГН-ийн байгаль хамгаалагчдыг өвөл, зуны дүрэмт хувцасны стандартыг шинэчлэн батлуулсан. 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр дүрэмт хувцас хүлээн авах ажлын комисс Хилийн цэргийн 0288 дугаар ангид ажиллаж үйлдвэрээс гарсан дүрэмт хувцсыг газар дээр нь үзэж, техникийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг хангаж байгаа эсэхийг шалгаж, Баруун бүсийн Тусгай хамгаалалттай газрын ХЗ-дад 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр гардуулан өгсөн. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Ажлын үр дүнд баруун бүсийн ТХГН-ийн ХЗ-дын нийт 240 албан хаагчийг оффисын болон хээрийн ажлын зориулалт бүхий 4 улирлын 17 нэр төрлийн иж бүрэн дүрэмт хувцсаар хангасан.<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин 2.5.10. Хог хаягдлын цогц менежмент 3R-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах загвар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлнэ*<br><br>**9. Хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, булшлах менежментийн зураглал хийх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 2.09/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/46 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу БОАЖЯ-наас зохион байгуулсан. |

| | | |
|---|---|---|
| | | БОАЖЯ-ын ТНБД-ын 2022 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн А/122 дугаар тушаалаар 69,826,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-19/22 22/110 дугаартай гэрээг "Байгаль орчин, эрүүл мэндийн төв" ТББ-тай 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан. Говь-Алтай аймгийн Цогт сумд хэрэгжиж буй уг ажлын тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцүүлж, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсний дагуу гүйцэтгэгч байгууллага тус оны 10 дугаар сарын 07-ны өдөр захиалагч талд танилцуулж эцэслэсэн тул, үлдэгдэл санхүүжилтийг 12 дугаар сарын 10-ны өдөр олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.2.4. Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.*<br><br>**10. Кластеруудын хэмжээнд ойн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх /ҮАТ 2.10/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 02 дугаар сарын 28-ны А/30 тоот тушаалаар Тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Үндэсний тендер шалгаруулалт "-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/372 дугаартай тушаалаар 973,320.935.3 төгрөгийн үнийн дүн бүхий №ҮТБ-08/22, 22/245 дугаартай гэрээг "Мөнх ногоон тал" ХХК-тай 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр байгуулж ажилласны дагуу 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 5 аймгийн 7 ойн ангийн 15 албан хаагчид "Техник тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, тээвэрлэлт, ачилт буулгалт, ашиглалтын бүхий л үе шатуудад мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй"-н сургалтыг танхимын болон дадлага хэлбэрээр зохион байгуулснаар Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс аймгийн сум дундын 7 ойн ангид тус бүр нэг 90 морины хүчин чадал бүхий дунд оврын трактор хөрс боловсруулах анжис, модны нүх ухагч өрөм, борной, далан гаргагч зэрэг 4 төрлийн дагалдах тоног төхөөрөмжийн хамт хүлээлгэн өгсөн. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Энэхүү ажлын үр дүнд Сум дундын ойн ангиуд орчин үеийн өндөр хүчин чадал бүхий техник, тоног төхөөрөмжийг ашигласнаар ойн арга хэмжээ механикжиж, ажлын бүтээмж эрс нэмэгдэж улмаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг орон нутгийн түвшинд амжилттай хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах бодит хөрөнгө оруулалт болсон.<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин 2.5.10. Хог хаягдлын цогц менежмент 3R-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах загвар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлнэ*<br><br>**11. ТХГН дахь хог хаягдлын менежментийн зөвлөх үйлчилгээ /ҮАТ 2.11/:** |
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>Хүрэх үр дүн: Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | |

| | | |
|---|---|---|
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>Хүрэх үр дүн: Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/151 дугаартай тушаалаар 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдөр 27,950,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-2/1721, 21/193 дугаартай гэрээг "Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн" ТББ-тай байгуулсны дагуу гүйцэтгэгч байгууллага нь ажлын эцсийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, тайланг хүлээлгэн өгсөн тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулж, 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр сүүлийн санхүүжилтийг олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.5. <u>Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.</u>*<br><br>**12. Цахим хурлын тоног төхөөрөмжөөр хангах /ҮАТ 2.12/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/57 дугаартай тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/410 дугаартай тушаалаар 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр "Ай Ти Эс Өү" ХХК-тай 574,147,000 төгрөгийн үнийн дүн бүхий БОЯБХУАӨДЗТөсөл/202207044, №22/322 дугаартай гэрээг байгуулсны дагуу гүйцэтгэгч байгууллага үнийн судалгаа, тоног төхөөрөмжийн захиалгыг хийж байна. Тоног төхөөрөмжийг 2023 оны эхний улиралд багтаан хүлээн авахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл 70%.**<br>Тус ажлаар Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Увс, Баянхонгор, аймгийн БОАЖГ-ыг 3 нэр төрлийн 15 ш, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Баян-Өлгий аймгийн сумдыг 3 нэр төрлийн 95 ш, Говь-Алтай аймгийн ИТХ, Увс аймгийн ЗДТГ тус тус 4 нэр төрлийн 4 ш, БОАЖЯ 2 төрлийн 2ш зэрэг нийт 7 нэр төрлийн 120 ширхэг ухаалаг дэлгэц, дууны өсгөгч, ухаалаг дэлгэцийн хөл, вэб камерийн ком, цахим хурлын дэлгэц, лед дэлгэц, зөөврийн компьютер зэрэг цахим хурлын тоног төхөөрөмжөөр хангаж, хурал семинар, сургалт, арга хэмжээг цахимаар зохион байгуулснаар, олон талыг хамруулах, оролцогчдын тоог нэмэгдүүлэх боломжийг нээсэн.<br><br>**13. Ховд аймгийн Алтай суманд ДЦГ-ын хамгаалалтын захиргааны барилга барих ажлын хүрээнд: /ҮАТ 2.13/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр А/376 дугаар тушаалаар Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны нэрийг "Зүүнгарын говийн ДЦГ-ын хамгаалалтын захиргаа" болгон өөрчилж тус хамгаалалтын захиргааг Ховд аймгийн Алтай сумын төвд шилжүүлэн байршуулахаар шийдвэрлэсэн шийдвэрийг өөрчилж, ГИДЦГ-ын "Б" хэсгийг Говь-Алтай, Ховд аймгийн засаг захиргааны нэгжийн хилээр зааглан 2 тусдаа хамгаалалтын захиргаатай байх, Ховд аймгийн нутаг дэвгэрт хамаарах хэсгийг хариуцсан хамгаалалтын захиргааг шинээр байгуулахаар шийдвэрлэсэн. Ажлын хүрээнд ГИДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны Мастер төлөвлөгөөг үндэслэн барилгын суурийн геологи, гидрологи, геодезийн |

| | | |
|---|---|---|
| | | дүгнэлт гаргах, барилгын ажлын зураг төсөл, төсвийг боловсруулах ажлыг Олон улсын Тахь группийн хөрөнгөөр "Билдинг Техноложи" компани гүйцэтгэж, Барилгын Хөгжлийн Төвөөр 2022 оны 06 сард батлуулсан. Тендерийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг төслийн барилгын зөвлөх баг "Некст степ инженеринг" ХХК боловсруулж, 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүлээлгэн өгсөн.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/339 дугаар тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсан бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/512 дугаартай тушаалаар үнэлгээний хорооны гишүүнийг шинэчилсэн. Төслийн санхүүжүүлэгч байгууллага KFW-аас 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон концепци шаардсантай холбогдуулан тус ажил 2023 онд хийгдэхээр хойшилсон болно. **Ажлын гүйцэтгэл 0%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга- Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес*<br>*3.3.15. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. /хурдасгуур хөтөлбөр, менторшип, co-work-ing space, түрээсийн хөнгөлөлт/*<br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга - Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт*<br>*3.4.2. Барьцаа хөрөнгийн, зээл авах хүсэлтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд Засгийн газрын зүгээс санхүүжилтийн баталгаа гаргах үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.*<br><br>**14. Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг эхлүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 2.14/:**<br>Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн ажлыг эхлүүлэхээр 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Төрийн банкны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, дараагийн шатны нийт 1.4 сая еврогийн санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэж, өмнөх гэрээний хэрэгжилтийн талаар тайлантай танилцаж, санал солилцсон. Үүний дагуу төслийн зөвлөх багийн судалгаагаар баруун бүсийн 15 сумыг сонгохоор шийдвэрлэсэн бөгөөд Эргэлтийн сангийн санхүүжилтийн гэрээг Төрийн Банктай байгуулах шатандаа байна. **Ажлын гүйцэтгэл 50%.** |
| | **2-р зорилтын хүрээнд:**<br>Хүрэх үр дүн: Томоохон нутаг дэвсгэрийг хамарсан холбоос нутаг буюу кластер нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | |
| | | **1. Сонгогдсон ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын суурь судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /ҮАТ 3.01/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын ын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/60 дугаар тушаалаар Тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/410 дугаартай тушаалаар 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр "Байгаль хамгааллын судалгаа хөгжлийн төв" НҮТББ-тай 62,736,300 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-21/22, 21/262 дугаартай гэрээг байгуулсны дагуу гүйцэтгэгч нь эцсийн тайланг төслийн дэргэдэх БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022 |

| | | |
|---|---|---|
| | **3-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан 7 ТХГ-ыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | оны 12 дугаар сарын 16-ны өдөр хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулсан. Үлдэгдэл төлбөрийг 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%**<br>Улсын тусгай хамгаалалттай 7 газар ажиллаж, төсөлд хамрагдсан ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын суурь мэдээллийг бүрдүүлсэн болно.<br><br>**2. Сонгогдсон ТХГН-ийн биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд: /ҮАТ 3.02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/297 дугаартай тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулж, гэрээ шууд байгуулах журмын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/427 дугаартай тушаалаар Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийг шалгаруулж, 65,880,000 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-22/22, 22/278 дугаартай гэрээг 2022 оны 10 дугаар 12-ны өдөр байгуулж ажилласны дагуу гүйцэтгэгч нь эхлэлийн тайланг хүргүүлсний дагуу эхний санхүүжилтийг олгосон. Гэрээний дагуу эцсийн тайланг 2023 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн дотор хүлээлгэн өгнө. **Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 100%.** /2022 онд гэрээ байгуулсан байх, 2023.07 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br>УТХГ-ын Говийн бага ДЦГ, Нөмрөгийн ДЦГ, Их газрын чулууны БЦГ, Дарьгангын БЦГ, Их Богдын БЦГ, Монгол элсний БЦГ, Говь гурван сайхны БЦГ нийт 7 УТХГ-т биологийн олон янз байдлын суурь судалгаа бүрдэнэ.<br><br>**3. ОБ-ийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг эхлүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 3.03/:**<br>Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн ажлыг эхлүүлэхээр 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Төрийн банкны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, дараагийн шатны нийт 1.4 сая еврогийн санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэж, өмнөх гэрээний хэрэгжилтийн талаар тайлантай танилцаж, санал солилцсон. Үүний дагуу төслийн зөвлөх багийн судалгаагаар сонгогдсон 7 ТХГ-ыг Эргэлтийн сангийн санхүүжилтийн гэрээг Төрийн Банктай байгуулах шатандаа байна. **Ажлын гүйцэтгэл 50%.**<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.*<br><br>**4. Байгаль орчны байгууллагуудад бартаат замын (16) автомашин нийлүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 3.04/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/544 дугаартай тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 20-нд тендерийг зарлан, урилга нийтлүүлэхээр ажиллаж байна.<br>Бартаат замын 16 автомашин нийлүүлэх хамгаалалтын захиргаад болон БОАЖГ-уудын нэрсийг тодруулан тэдгээрээс үйл ажиллагааны, урсгал болон засвар үйлчилгээний зардлуудыг тухайн газрууд төсөвтөө суулгасан гэсэн амлалтуудыг бичгээр |

| | | |
|---|---|---|
| | **3-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан 7 ТХГ-ыг тогтоосон шалгуурын дагуу сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | авч байж тендерийн баримт бичиг болон ажлын даалгаврыг батлуулах шаардлагатай гэсэн KfW банкны зөвлөмжийн дагуу БОАЖЯ-наас 16 газрын нэрсийг тодруулж өгөх хүсэлтийг өгснөөс одоогийн байдлаар 11 нь тодорхой болж 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр чиглэл хүргүүлсэн. Үүнд:"Монгол элс, Нөмрөг, Говь гурван сайхан, Говийн бага, Дарьганга, Их газрын чулуу, Их богд, Тужийн нарс, Гутайн даваа-хөмүүл голын эх, Их нарт, Тост тосон бумбын нуруу зэрэг болно. **Ажлын гүйцэтгэл гэрээний дагуу 100%.** /2023.08 сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөгөөнд туссан./<br><br>**5. ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд /ҮАТ 3.05/:**<br>Тус зөвлөх үйлчилгээг Төслийн Зөвлөх баг богино хугацааны зөвлөхөөр гүйцэтгүүлэхээр ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж, эцэслэсний дагуу гүйцэтгэгчийн ажлын гэрээг 2022 оны 10 дугаар сард байгуулж, зөвлөхийн тайланг 12 дугаар сард хүлээн аваад байна. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсэгт хамрагдахаар шалгуур үзүүлэлтээр сонгогдсон Говийн бага ДЦГ, Нөмрөгийн ДЦГ, Их газрын чулууны БЦГ, Дарьгангын БЦГ, Говь гурван сайхны БЦГ, Их Богдын БЦГ, Монгол элсний БЦГ зэрэг УТХГ-ын менежментийн төлөвлөгөөг төслийн зөвлөх багийн зүгээс шинэчлэн боловсруулснаар тус УТХГ-ууд 2022-2026 оны менежментийн төлөвлөгөөтэй болсон. |
| | **4-р зорилтын хүрээнд:**<br>**Хүрэх үр дүн:**<br>ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | **1. СЯ, БОАЖЯ болон бусад талуудтай хууль эрх зүй, бодлого зохицуулалтын уулзалт, ТХГН-ийн дэд бүтцийн стандарт боловсруулах, төсөлд оролцогч талуудыг хамруулан төслийн бодлого, чиглэл үйл явц, үр дүнг хэлэлцүүлэх, санал авах хурал зөвлөгөөн, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 4.01/:**<br>Тайлант хугацаанд Төсөл хэрэгжүүлэгч нэгж, Зөвлөх баг, БОАЖЯ болон бусад оролцогч талуудыг чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэхүү сургалт, уулзалт зөвлөгөөнийг цар тахлын үед мөрдөх журмыг баримтлан цахимаар зохион байгуулсан болно.<br>• БОАЖЯ, холбогдох Төрийн бус байгууллагуудтай хамтран "Бид байгаль хамгаалагчид" Байгаль хамгаалагчийн үндэсний чуулганыг 2022 оны 03 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгуулсан.<br>• KfW банкны "Түншлэгч улсуудтай хийх Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөх үйлчилгээ, Ажил, Үйлдвэр, Барааны болон Зөвлөхийн бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам"-ын дагуу төслийн ХАА-нд мөрдөж байгаа худалдан авах ажиллагааны журмын талаар нэгдсэн ойлголт бий болгох зорилгоор танилцуулга-цахим уулзалтыг ТХН, Зөвлөх багтай хамтран БОАЖЯ-ны газар хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Төрийн бус байгууллагын төлөөллүүдэд зориулж 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан.<br>• НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ФАО), Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр хамтран зохион байгуулж буй "Газрын менежмент"-ийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудын зөвлөлдөх уулзалтад төслийн танилцуулга илтгэл тавьж оролцлоо. Тус уулзалтаар төслүүдийн үйл ажиллагааны давхцалыг текстийн шинжилгээний аргаар зураглах |

| | | |
|---|---|---|
| | | болон зураглалын үр дүнд суурилан цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оролцож ажилласан.<br>• БОАЖ-ын сайдын 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/176 дугаар "Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж буй албан хаагчдын хувцас, нэг бүрийн тусгай хэрэгслийн жишиг жагсаалт батлах тухай" тушаалаар ТХГН-ийн хувцас, тоног төхөөрөмжийн стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**2. ЮНЕСКО-ийн Хүн ба шим мандлын хөтөлбөрт зарим ТХГН-ийг бүртгүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 4.02/:**<br>Тус ажлыг БОАЖЯ-ны ТХБНУГ-аас төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасны дагуу 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Төслийн удирдах хорооны хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсний дагуу БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/387 дугаартай тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулж, гэрээ шууд байгуулах журмын дагуу 66,000,000.00 төсвийг батлуулсан. Захиалагч талаас ажлын даалгавар боловсруулж дуусаагүйтэй холбогдуулан тус ажил төслийн үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар он дамжиж хийгдэхээр болоод байна. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.** |
| | **4-р зорилтын хүрээнд:**<br>Хүрэх үр дүн: ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | *Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил- Шинжлэх ухаан, инноваци 2.4.12. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд суурилсан шагнал, урамшууллын тогтолцоог бий болгоно.*<br><br>**3. Биологийн олон янз байдлын мэргэжлийн зөвлөлийн хурлууд зохион байгуулах ажлын хүрээнд /ҮАТ 4.03/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/65 дугаартай тушаалаар байгуулсан БОЯБ-ын мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн урамшууллыг шийдвэрлэх тухай албан хүсэлтийг төслийн 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 102/2022 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсний дагуу нийт 3,800,000.00 төгрөгийн урамшууллыг шийдвэрлүүлсэн. Тус зөвлөлөөр 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр "ТХГН дахь хог хаягдлын менежментийн зөвлөх үйлчилгээ", ажлыг 09 дүгээр сарын 14-ний өдөр "Хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, булшлах менежментийн зураглал хийх зөвлөх үйлчилгээ", 10 дугаар сарын 17-ны өдөр "Бэлчээрийн суурь судалгааны зөвлөх үйлчилгээ", 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр "Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өндөр уулсын ургамлын нэн ховор, ховор, мэдрэг түлхүүр зүйлийн суурь судалгаа хийх", 2022 оны 12 дугаар сарын 28-ний өдөр "Биологийн олон янз байдлын суурь судалгааны зөвлөх үйлчилгээ"-ний ажлуудын эцсийн тайланг тус тус хэлэлцүүлж, холбогдох ажлуудыг хүлээн авахаар шийдвэр гаргуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**4. ТХГН-ийн газар ашиглалтын үйл ажиллагааг цахимжуулах, хөгжүүлэлт хийх ажлын хүрээнд /ҮАТ 4.04/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/388 дугаартай тушаалаар Тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк |

| | | |
|---|---|---|
| | **4-р зорилтын хүрээнд:**<br>Хүрэх үр дүн: ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | (KfW)-ны “Гэрээ шууд байгуулах журам”-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/424 дугаартай тушаалаар 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “Софт мастер” ХХК-тай 59,400,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-24/22, 22/273 дугаартай гэрээг байгуулсны дагуу гүйцэтгэгч нь эцсийн тайланг 12 дугаар 09-ний өдөр хүлээлгэн өгснийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр захиалагч тал болох БОАЖЯ-ны холбогдох газраар хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулсан. Үлдэгдэл төлбөрийг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр шилжүүлсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>*БОАЖЯ-ны салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө Байгаль орчныг хамгаалах УЦУ орчны хяналт шинжилгээ- 5. Байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах*<br><br>**5. Биологийн олон янз байдлын мэдээллийн санг шинэчлэх, зураглал хийх ажлын хүрээнд /ҮАТ 4.05/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/37 тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу БОАЖЯ-ны ХБОБНУГ-аас зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч, тус тендерийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ын ТНБД-ын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/244 дугаар албан бичгээр *59,400,000.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ЗСШ-27/22 дугаартай гэрээг “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн”-тэй 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байгуулсны дагуу гүйцэтгэгч нь эцсийн тайланг 2022 оны 12 дугаар 12-ны өдөр хүлээлгэн өгснийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр захиалагч талыг байлцуулан хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулсан. Үлдэгдэл төлбөрийг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр шилжүүлсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Энэхүү ажлын үр дүнд биологийн олон янз байдлын судалгааны үр дүнг мэдээллийн санд шинэчилсэн болно.<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.2.Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.*<br><br>**6. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өндөр уулсын ургамлын нэн ховор, ховор, мэдрэг түлхүүр зүйлийн суурь судалгаа хийх ажлын хүрээнд /ҮАТ 4.06/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/255 дугаар тушаалаар Тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу тус тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны “Гэрээ шууд байгуулах журам”-ын дагуу зохион байгуулсан.<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/311 дугаартай тушаалаар 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Математик, Байгалийн Ухааны сургууль”-тай 64,500,000 төгрөгийн үнийн дүн |

| | | |
|---|---|---|
| | | бүхий ГШБ-10/22, 22/180 дугаартай гэрээг байгуулсны дагуу гүйцэтгэгч нь эцсийн тайланг 11 дүгээр 29-ний өдөр хүлээлгэн өгснийг төслийн дэргэдэх БОЯБ-ын зөвлөлөөр 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан тул тайлан хүлээн авсан болон гэрээ дүгнэсэн актыг албажуулсан. Үлдэгдэл төлбөрийг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр шилжүүлсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.** |
| 6 | Төслийн ерөнхий менежмент | **1. 2022 оны үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах ажлын хүрээнд /PM01/:**<br>Төслийн удирдах хорооны 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар 2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулан, 2022 оны ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлсний дүнд төслийн 2022 оны үйл ажиллагааны болон ХАА-ны төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр БОАЖЯ-ны ТНБД-аар батлуулсан. Төслийн удирдах хорооны 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хурлаар “Биологийн олон янз байдлын мэдээллийн санг шинэчлэх, зураглал хийх”, “Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өндөр уулсын ургамлын нэн ховор, ховор, мэдрэг түлхүүр зүйлийн суурь судалгаа хийх” зэрэг 2 ажлыг төслийн үйл ажиллагаанд нэмж оруулах шийдвэр гарснаар үйл ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн батлуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**2. Төслийн 2021 оны үйл ажиллагаанд баталгаажуулалтын аудит болон санхүүгийн тайлангийн аудит хийх, 2022 оны үйл ажиллагаанд баталгаажуулалтын аудит болон санхүүгийн тайлангийн аудит хийх гэрээ байгуулах ажлын хүрээнд /PM02/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/207 дугаартай тушаалаар “Төслийн 2021 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх” ажлын ҮАГ/АА 2021-171С дугаартай гэрээг 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр “Интер аудит” ХХК-тай байгуулж ажилласны дагуу эцсийн тайланг 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн дотор хүлээн авсан. Аудитын тайланг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Германы сэргээн босголт зээлийн банк (KfW)-нд хүргүүлсэн. Аудитын зөвлөмжийн дагуу ХАА-г цахимжуулж, https://www.tender.gov.mn/mn/index/ хуудсаар зарлах зэрэг биелэлтийг гарган хүргүүлсэн.<br>“Төслийн 2022 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх” ажлын ҮАГ/АА 2022-191, 23/01 дугаартай гэрээг 2022 оны 10 дугаар сарын 14-ний болон 11 сарын 01-ний өдөр Үндэсний аудитын газар, “Интер аудит” ХХК-тай тус тус байгуулсны дагуу шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна. Ажлын эцсийн тайланг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор хүлээн авахаар ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**3. Төслийн Удирдах хорооны хурлыг зохион байгуулах ажлын хүрээнд /PM03/:**<br>Төслийн удирдах хорооны хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулж, шийдвэрлэх асуудлыг хэлэлцэж, төслийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталсан. 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр удаах хурлыг зохион байгуулж, 2022 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, |

| | | |
|---|---|---|
| | Төслийн ерөнхий менежмент | төслийн ажилтан нарын үр дүнгийн гэрээний биелэлт, үнэлгээ болон бусад холбогдох шийдвэрлэх асуудлыг хэлэлцэж, төслийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 12 дугаар сарын 26-ны өдөр,төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 12 дугаар сарын 28-ны өдөр тус тус батлуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**4. KfW банкнаас Төслийн явцын үнэлгээний баг ирж ажиллах ажлын хүрээнд /PM04/:**<br>• БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Төслийн явцын үнэлгээний 1 дүгээр баг 2022 оны 05 дугаар сарын 01-08-ны өдрүүдэд Төв, Өвөрхангай, Архангай, Завхан, Увс, Ховд аймгуудад, 2 дугаар баг тус оны 05 дугаар сарын 03-08-ны өдрүүдэд Хэнтий, Сэлэнгэ, Төв аймагт тус тус томилолтоор ажиллаж, төслийн II, III шатны хэрэгжилт, тайлантай танилцах, кластерууд, ТХГН-ийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцах, анхаарах асуудлаар хэлэлцэх, төслийн I үе шатанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын хэрэгжилт, үр дүнтэй танилцах, үнэлгээ хийх, төслийн үйл ажиллагаанд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэж ажиллалаа. Удирдамжийн дагуу ажлын тайланг гаргаж, илтгэх хуудасны хамт БОАЖЯ-ны холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан. Томилолтын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр БОАЖЯ, Сангийн яам болон төслийг хамтран хэрэгжүүлж холбогдох талуудтай уулзалт, хэлэлцүүлгийг хийж, үнэлгээний үеэр тохирсон ажлуудыг гарын үсэн зуран, баталгаажуулсан.<br>• Төслийн зөвлөх баг “Эко консалтинг, Зепп Бусакер Түншлэл” ХХК-ны дарга Зепп Бусакер, төслийн I шатны техникийн ахлах зөвлөх 2022 оны 03 дугаар сарын 20-ноос 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд Монгол ирж ажиллаж байгаатай холбогдуулан 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр ТХН-тэй уулзалтыг зохион байгуулсан.<br>• Төслийн 3-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 7 ТХГН-ийг сонгох ажлын хүрээнд KfW банкнаас Говийн бага ДЦГ, Говь гурван сайханы БЦГ-ыг оруулахыг тус тус дэмжсэний дагуу KfW банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын захирал М.Зумзер, Төслийн захирал Д.Батмөнхийн ахалсан үнэлгээний ажлын хэсэг 2022 оны 03 дугаар сарын 07-12-ны өдрүүдэд холбогдох УТХГ-уудад, төслийн зөвлөх багийн техникийн дэд ахлах зөвлөх П.Галрагчаагийн ахалсан ажлын хэсэг 2022 оны 04 дүгээр сарын 13-19-ний өдрүүдэд Нөмрөгийн БЦГ, Дарьгангийн БЦГ-т тус тус ажиллаж, үнэлгээг хийсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.** |
| 7 | | **1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулахад дэмжлэг үзүүлэх /M01/:**<br>Төслийн зөвлөх багийн Байгаль орчин, нийгмийн асуудлын олон улсын зөвлөх Май Флиннээр ахлуулсан төслийн БОННМ-ийн баг 05 сарын 01-09-ний өдрүүдэд Монголд ажилласан томилолтын хүрээнд БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэстэй хийсэн уулзалтын үеэр дээрх ажлыг төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр хүсэлтийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Төслийн удирдах хорооны хурлаар хэлэлцэж, захиалагч талаас хуулийн төслийг ирүүлэхээр шийдвэрлэсэн. Захиалагч талаас хуулийн төслийг боловсруулж дуусаагүйтэй холбогдуулан тус ажил төслийн үйл ажиллагаанаас үл хамаарах |

| | | |
|---|---|---|
| | Мониторинг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент | шалтгаанаар он дамжиж хийгдэхээр болоод байна. **Ажлын гүйцэтгэл үнэлэхгүй.**<br><br>**2. Ховд аймаг дахь ХЗ-ны барилгад байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх /М02/:**<br>Тус зөвлөх үйлчилгээг Төслийн Зөвлөх баг богино хугацааны зөвлөхөөр гүйцэтгүүлэхээр ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж, эцэслэсний дагуу гүйцэтгэгчийн ажлын гэрээг 2022 оны 10 дугаар сард байгуулж, зөвлөхийн тайланг 12 дугаар сард хүлээн аваад байна. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**3. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент болон ХАБЭА-н талаарх сургалтыг зохион байгуулах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд /М03/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан үнэлгээний хороо байгуулах тухай А/81 дүгээр тушаалд өөрчлөлт оруулах тухай А/119 дүгээр тушаал 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан.<br>Багц 1: "Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент (БОННМ)-ийн бодлогыг хэрэгжүүлэх арга зүйн сургалт хийх":<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/191 дугаартай тушаалаар *85,523,600.00 төгрөгийн* үнийн дүн бүхий ҮТБ-№02/0621 дугаартай гэрээг ""Би Жи Эм Дистрибьюшн" ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага нь "Байгаль орчин нийгмийн нөлөөллийн бодлогыг хэрэгжүүлэх аргазүй" сургалтыг БОАЖЯ-ны ТХБНУГ, БОҮАХ болон УТХГ-ын Говийн бага ДЦГ болон Нөмрөгийн ДЦГ, Их газрын чулуу БЦГ, Говь гурван сайханы БЦГ, Дарьгангын БЦГ-уудын Хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтэн, ТХН, зөвлөх багийн нийт 25 хүний оролцоотойгоор 2022 оны 06 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж, шалгалтад тэнцсэн оролцогч нарт гэрчилгээ олгосон. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br>Сургалтын хүрээнд "Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ", "Нийгэм-Жендер", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" гэсэн үндсэн 3 чиглэлээр Монгол Улс, Дэлхийн банк болон Германы Сэргээн Босголт, Зээлийн Банкны холбогдох хууль, дүрэм, стандарт, бодлогыг танилцуулж, дасгал, тест, шалгалтаар баталгаажуулсаар нийт оролцогч нарын мэдлэгийг дээшлүүлж, чадавхыг сайжруулсан.<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Эрүүл мэнд*<br>*2.2.4 "Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг*<br>*2.2.5. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага бүр ажилтан албан хаагчдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамруулдаг соёлыг хэвшүүлнэ*<br><br>Багц 2: "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх":<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/190 дугаартай тушаалаар *108,150,000 төгрөгийн* үнийн дүн |

| | | |
|---|---|---|
| | Мониторинг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент | бүхий ҮТБ-№02/0620 дугаартай гэрээг "Симплүүд Тек" ХХК & "Ивээл Луу" ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс Баруун бүсийн УТХГ-т ажиллаж, байгаль хамгаалагч, ажилтан нарын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн ажлыг гүйцэтгэсэн. 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсэгт сонгогдсон нийт 5 ХЗ-ны ажилтан, байгаль хамгаалагч нарт ХАБ-ын сургалтыг цахимаар зохион байгуулсан. Ингэснээр УТХГ-ын Баруун болон Говийн бүс, сонгогдсон 7 ХЗ-ны нийт 220 хүнийг эрүүл мэндийн багц үзлэгт оруулж, 300 хүнийг ХАБ-ын танхимын болон цахим сургалтад тус тус хамруулсан. **Ажлын гүйцэтгэл дунджаар 100%.**<br><br>**4. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, багаж хэрэгслээр хангах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд / М04/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/29 тушаалаар Тендерийн үнэлгээний хороог байгуулсны дагуу тендерийг Сэргээн босголт, зээлийн банк (KfW)-ны "Гэрээ шууд байгуулах журам"-ын дагуу зохион байгуулсан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/117 дугаартай тушаалаар *52,184,660 төгрөгийн* үнийн дүн бүхий №ҮТБ-09/22 дугаартай гэрээг "Эйч-Эс-Ти" ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллага нь хөдөлмөр хамгааллын хувцсыг 2022 оны 07 дугаар сард бүрэн хүлээлгэн өгсөн. **Ажлын гүйцэтгэл 100%.** |
| 8 | Төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн зардал | **1. ТХН-ийг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангах /5.01/:**<br>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн оффис 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн солигдсон болон 2022 оны 09 дүгээр сарын 3Г-ны хуралдаанаар БОАЖЯ-ыг нүүх шийдвэр гарсантай холбогдуулан оффисыг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг төлөвлөсөн ч Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаартай "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолтой холбогдуулан тус ажил хийгдээгүй.<br>**2. Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн бичиг баримтын мэргэжлийн орчуулга хийлгэх зардал /5.02/:**<br>Төслийн I шат 2022 оны 12 дугаар сард дуусаж байгаатай холбогдуулан хаалтын ажиллагаатай холбоотой баримт бичгийг орчуулах ажлыг төлөвлөсөн ч Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаартай "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолтой холбогдуулан тус ажил хийгдээгүй.<br>**3. Төслийн үйл ажиллагааны танилцуулга боловсруулж, олон нийтэд түгээж сурталчлах /5.03/:**<br>Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаартай "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолтой холбогдуулан тус ажил хийгдээгүй.<br><br>*Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хөдөлмөрийн зах зээл*<br>*2.6.15. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүн амын аюулгүй байдлыг хангах болон мэргэжлийн өндөр ур чадвар,* |

| | | |
|---|---|---|
| | | *технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулна.*<br><br>**4. Төсөл хэрэгжүүлэх зөвлөх багийн төлбөр /5.04/**<br>2022 оны 01 дүгээр сараас 2022 оны 07 дугаар сар хүртэлх хугацаанд төслийн хэрэгжүүлэгч зөвлөх багийн төлбөрт нийт евро 357,619.44 буюу 1,180,144,152.00 төгрөгийн санхүүжилт хийгдээд байна. **Ажлын гүйцэтгэл 100%**. |
| 9 | Тайлан | **1. Хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж БОАЖЯ, СЯ-д хүргүүлэх/ R01/:**<br>Төслийн I болон II шатны үйл ажиллагааны тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хавсралтын дагуу 2021 оны эцсийн байдлаар, 2022 оны хагас жилийн байдлаар тус тус гаргаж, БОАЖЯ-ны ГХАХ-т 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 06/2022 дугаартай, 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 84/2022 дугаартай албан тоотоор тус тус хүргүүлсэн. Тайлангийн хувийг төслийн зөвлөх баг болон БОАЖЯ-ны ТХБНУГ-т илгээсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**2. Улирал, хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг KfW банканд илгээх/ R02/:**<br>Төслийн үйл ажиллагааны тайланг улирал тутам, Санхүүгийн үйл ажиллагаа, ашиглалтын тайлан мэдээг сар бүр БОАЖЯ, СЯ-аар баталгаажуулан KfW-банканд тус тус тайлагнасан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**3. Тусгай дансны татан авалт, зарцуулалтын тайланг KfW банкинд илгээх ажлын хүрээнд /R.03/:**<br>Төслийн II үе шатны татан авалтын тайланг БОАЖЯ болон Сангийн яамаар баталгаажуулан 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр болон 11 дүгээр сарын 10-ны өдөр ХБНГУ руу тус тус хүргүүлсэн. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**4. Шилэн данс, ODAMIS, www.shilen-dans.mn, E-report, E-tailan-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээх ажлын хүрээнд /R.03/:**<br>Төслийн I, II шатны хяналт, шинжилгээ үнэлгээний тайланг "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"-ын хавсралтын дагуу 2021 оны эцсийн байдлаар гаргаж, Сангийн яамны https://odamis.mof.gov.mn цахим хуудсанд 2022 оны 03 дугаар сард байршуулсан.<br>НӨАТ-ын тайланг цаасаар болон цахим хэлбэрээр сар бүр хийж Татварын ерөнхий газарт хүргүүлж байна.<br>Шилэн дансны тайлан мэдээг сар бүр шинэчлэн хийж, БОАЖЯ-ны дотоод аудит хяналт үнэлгээний газарт улирал бүр нэгтгэн цахимаар илгээж ажилласан. **Ажлын гүйцэтгэл 100%**<br>**5. Шилэн данс, ODAMIS, www.shilen-dans.mn, E-report, iec.mn, E-tailan-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээх/ R04/:**<br>Төслийн үйл ажиллагааны хүрээнд гарсан тушаал, шийдвэрүүдийг шилэн данс, ODAMIS, eic.mn цахим системүүдэд оруулан бүртгэх. Нэгдсэн тайлан мэдээг тухай бүр E-tailan-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээсэн. |

<table>
<tr><td></td><td>Тайлан</td><td>www.shilen-dans.mn цахим хуудаснаа сар бүрийн 08-ний дотор оруулах төслийн ХАА-ны мэдээллийг нэгтгэн цахимаар илгээж ажилласан. Ажлын гүйцэтгэл 100%<br><br>6. Санхүүгийн ерөнхий тайлан:<br>• НӨАТ-ын тайланг цаасаар болон цахим хэлбэрээр сар бүр хийж Татварын ерөнхий газарт хүргүүлж байна.<br>• Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж байна.<br>• Хүн амын орлогын албан татварын тайланг сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст хүргүүлж байна.</td></tr>
<tr><td>10</td><td>Дүгнэлт (ололт, амжилт, дутагдал, анхаарах асуудлууд)</td><td>Ололт, амжилт:<br>• ХАА-г олон нийтэд илүү хүргэх, нээлттэй ил тод зарлах үүднээс тендерийг (tender.gov.mn) цахимаар зохион байгуулах ажлыг эхлүүлсэн.<br>Цаашид анхаарах асуудлууд, дутагдал:<br>• Төслийн I үе шатнаас авсан сургамж дээр анхаарч, алдаа дутагдлыг давтахгүй ажиллах</td></tr>
<tr><td>11</td><td>Төслийг хэрэгжүүлэгч талуудын х/а-нд өгөх хөндлөнгийн үнэлгээ</td><td>Төслийн үйл ажиллагааг үнэлэх зорилгоор санхүүжүүлэгч байгууллага болох Германы сэргээн босголт зээлийн (KFW) банкнаас төслийн явцын үнэлгээний баг 2022 оны 05 сарын 01-09-ний өдрүүдэд Монголд ирж ажиллан, төслийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн.</td></tr>
<tr><td>12</td><td>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)</td><td>
<table>
<tr><td rowspan="3">Биелэлт дундаж %</td><td>Менеж мент</td><td>Зорилт 1</td><td>Зорилт 2</td><td>Зорилт 3</td><td>Зорилт 4</td><td>Мони торинг, [illegible]</td><td>ТХН, ЗБ</td></tr>
<tr><td>100 %</td><td>83 %</td><td>71,5 %</td><td>90 %</td><td>100%</td><td>100 % %</td><td>100%</td></tr>
<tr><td>Нийт 4 ажлаас 4 ажил-100%</td><td>Нийт 10 ажлаас, 8 ажил- 100%, 1 ажил- 30%, 1 ажил- 0</td><td>Нийт 14 ажлаас 10 ажил- 100%, 1 ажил- 70%, 1 ажил- 50%, 2 ажил- 0</td><td>Нийт 5 ажлаас 4 ажил- 100%, 1 ажил- 50%</td><td>Нийт 6 ажлаас, 5 ажил-100%, 1 ажил- үнэлэхгүй</td><td>Нийт 4 ажлаас , 3 ажил 100%, 1 ажил- үнэлэхгүй</td><td>Нийт 4 ажлаас , 1 ажил 100%, 3 ажил- үнэлэхгүй</td></tr>
<tr><td></td><td colspan="7">2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт 47 ажил төлөвлөсөн.<br>Үүнээс: 5 ажил үнэлээгүй. Үүнд:<br>Хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан доорх 3 ажлыг хэрэгжүүлэхийг Сангийн яамнаас зөвшөөрөөгүй болно.<br>1. ТХН-ийг шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангах /5.01/</td></tr>
</table>
</td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2. Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн бичиг баримтын мэргэжлийн орчуулга хийлгэх зардал /5.02/:<br>3. Төслийн үйл ажиллагааны танилцуулга боловсруулж, олон нийтэд түгээж сурталчлах /5.03/<br>БОАЖЯ-наас захиалгатай доорх 2 ажлыг захиалагч тал шаардлаггүй гэж үзсэн.<br>4. ЮНЕСКО-ийн Хүн ба шим мандлын хөтөлбөрт зарим ТХГН-ийг бүртгүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд /ҮАТ 4.02/<br>5. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулахад дэмжлэг үзүүлэх /М01/<br>**Үнэлсэн**: Нийт **42 ажил.**<br>100%-тай=35=3500 /үр дүнтэй, бүрэн хэрэгжиж дууссан/<br>70%-тай=1=70 /гэрээ хэрэгжих шатандаа, өөрсдөөс хамаарах шийдвэр гарсан/<br>50%-тай=2=100 /боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, гэрээ байгуулагдах шатандаа/<br>30%-тай=1=30 /боловсруулалтын шатандаа гэрээ байгуулагдах шатандаа/<br>3 ажил =0 /хийгдээгүй буюу 2023 он руу шилжиж хойшилсон/<br>Үүнд:<br>1. Байгаль хамгаалагчийн байр болон хөдөлгөөнт хяналтын постын барилгын ажлын зураг, төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажил /ҮАТ 1.07./<br>2. Баруун бүсийн Сургалт, судалгаа, мэдээллийн төвийн барилгын хөрсний геологи, геодезийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, барилгын ажлын зураг, төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ /ҮАТ 2.04./<br>3. Ховд аймгийн Алтай суманд ДЦГ-ын хамгаалалтын захиргааны барилга барих */Тендер зарласан байна/* /ҮАТ 2.13./ | | | |
| | | **Төслийн II,III шатны үйл ажиллагааны хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 88%-ийн биелэлттэй байна.** | | | |
| 13 | ЗГХЭГ-ын үнэлгээ | Нэгдсэн үнэлгээ | | | |
| | | ... % | | | |
| **Нэмэлт мэдээлэл /сая төгрөгөөр/** | | | | | |
| 14 | Зарцуулалт | 2019 | 2020 | 2021 | 2022 |
| | ХБНГУ-ын Засгийн газар | | 2,257.18₮ | 3,353.03₮ | 6,626.60 ₮ |
| | МУ-ын Засгийн газар | 52.09 ₮ | 546.71 ₮ | 697.07₮ | 748.6₮ |
| 15 | Жендерийн мэдээлэл | Төслийн хүрээнд “Нийгэм-Жендерийн сургалт”-ыг Монгол Улс, Дэлхийн банк болон Германы Сэргээн Босголт, Зээлийн Банкны Нийгэм-Жендерийн бодлогын бичиг баримтын дагуу 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр БОАЖЯ, ТХН болон УТХГ-ын холбогдох хамгаалалтын захиргааны нийт 25 хүний оролцоотой, 10 дугаар сарын 02-14-ний өдрүүдэд Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн БОАЖГ-ийн төлөөлөл бүхий нийт 90 хүний оролцоотойгоор тус тус зохион байгуулснаар жендерийн тэгш байдал, жендерийн хамгааллын бодлого, эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн оролцооны ач холбогдол, хүн худалдаалах, | | | |

| | | |
|---|---|---|
| | | жендерт суурилсан бэлгийн хүчирхийлэл, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг сэдвээр мэдлэг олгосон. |
| 16 | Суурь судалгаа хийгдсэн эсэх | “Ойн тогтвортой менежментийн суурь судалгаа” /ҮАТ 1.04./-г 2022 оны 02 дугаар сард, “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын суурь судалгаа” /ҮАТ 1.03./-г 04 дүгээр сард, “Бэлчээрийн тогтвортой менежментийн (баруун 4 аймгийн 10 суманд) суурь судалгаа” /ҮАТ 1.02./-г 09 дүгээр сард, “Биологийн олон янз байдлын суурь судалгаа” /ҮАТ 1.01./-г 12 дугаар сардтус тус хүлээн авч, тухай бүрд нь төслийн дэргэдэх Биологийн олон янз байдлын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. |

ХЯНАСАН:

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Г.ЭРДЭНЭБАЯСГАЛАН

БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН Ц.ЭНХСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ
БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ... УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ ТБАГ
9020070899

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН-2022.12.31

*Төгрөгөөр/еврогоор*

| | Тайлант хугацаанд 2022.12.31 | | Өссөн дүнгээр | |
|---|---|---|---|---|
| **Орлого** | **Евро** | **Төгрөг** | **Евро** | **Төгрөг** |
| KfW | | | | |
| Шууд санхүүжилт(Зөвлөх) | 357,619.44 | 1,137,995,124.80 | 1,725,451.53 | 5,866,535,202.00 |
| Хялбаршуулсан шууд төлбөр | 665,680.53 | 2,159,144,118.28 | 665,681.53 | 2,227,117,440.40 |
| Татан төвлөрүүлэлтийн данс | 1,446,000.00 | 4,973,843,070.00 | 1,854,921.17 | 6,306,731,978.00 |
| **KfW-орсон нийт санхүүжилт** | **2,469,299.97** | **8,270,982,313.08** | **4,246,054.23** | **14,400,384,620.40** |
| Хүүгийн орлого | | | | |
| МУЗГ | | | | |
| Төрийн сан | 236,933.88 | 852,962,000.00 | 662,508.99 | 2,252,530,566.00 |
| **Нийт санхүүжилт/Орлого** | **2,706,233.85** | **9,123,944,313.08** | **4,908,563.22** | **16,652,915,186.40** |
| Зардал | | | | |
| KfW | 1,893,301.18 | 6,626,554,130.00 | 3,498,124.35 | 11,893,622,790.00 |
| МУЗГ | 213,884.59 | 748,596,068.53 | 393,477.82 | 1,296,007,816.18 |
| МУЗГ-т буцаан шилжүүлсэн | | | | |
| Гадаад ханшийн зөрүү | | (134,287,394.71) | | |
| **Нийт зардал** | **2,107,185.77** | **7,240,862,803.82** | **3,891,602.17** | **13,189,630,606.18** |
| Үр дүн | 575,998.79 | 1,883,081,509.26 | 747,928.88 | 2,744,166,019.30 |
| Урьдчилгаа | | | - | |
| **Цэвэр мөнгөн хөрөнгө** | **171,930.09** | **554,128,960.77** | **-** | **-** |
| Эхний үлдэгдэл | | | | |
| KfW | | | | |
| Тусгай данс | 171,930.09 | 554,128,960.77 | | |
| Дэд данс | | | | |
| **KfW-ийн нийлбэр** | **171,930.09** | **554,128,960.77** | | |
| МУЗГ | | | | |
| Төрийн сан | | | | |
| **Эхний үлдэгдлийн нийлбэр** | **171,930.09** | **554,128,960.77** | | |
| **Эцсийн үлдэгдэл** | **747,928.88** | **2,744,166,019.30** | **747,928.88** | **2,744,166,019.30** |
| KfW | | | | |
| Тусгай данс | 747,928.88 | 2,744,166,019.30 | 747,928.88 | 2,744,166,019.30 |
| Дэд данс | | | | |
| **KfW-ийн эцсийн үлдэглийн нийлбэр** | **747,928.88** | **2,744,166,019.30** | **747,928.88** | **2,744,166,019.30** |
| МУЗГ | | | | |
| Төрийн сан | | | | |
| **Эцсийн үлдэглийн нийлбэр** | **747,928.88** | **2,744,166,019.30** | **747,928.88** | **2,744,166,019.30** |

Тусгай лансны ханш орлого орж ирсэн өдрийн монгол банкны албан ханшаар

Дэд дансны ханш нь тусгай данснаас шилжүүлэг хийсэн өдрийн арилжааны банкны ханшаар

МУГЗ-ын санхүүжилт орж ирсэн өдөр болгоны монгол банкны албан ханшаар